

**Энэ дэлхийн  
амьдралаас өөр  
амьдрал бий юу?**



# **Эммай тосгоны замд таарадсан ҮЛ ТАНИХ ХҮН**

**Жон Р. Кросс**

Эммай тосгон орох замд тааралдсан үл таних хүн  
1 дэх хэвлэл

Зохиогчийн эрхийг © 2013 Goodseed® International эзэмшинэ.

Зохиогчийн эрх хадгалагдана. Хэвлэгчдийн бичгэн зөвшөөрөлгүйгээр энэхүү номын аль ч хэсгийг ямар нэгэн хэлбэрээр ашиглахыг хориглоно. GoodSeed, [www.goodseed.com](http://www.goodseed.com) болон уг номын загвар дизайн нь GoodSeed International байгууллагын баааны тэмдэг болно.

GOODSEED® International байгууллага хэвлэв  
P.O. Box 3704, Olds, Alberta, Canada  
Email хаяг: [info@goodseed.com](mailto:info@goodseed.com)

ISBN: 978-1-927429-12-9

Монгол Улсад хэвлэв

201301-145-2000

## Талархал

Энэ номыг бүтээлцэхэд хувь нэмрээ оруулсан олон хүнд би чадахынхаа хирээр талархлаа илэрхийлэхийг хүслээ. Энэтхэг, Солонгос, Сингапур, Молдов, Нэгдсэн Вант Улс, Герман, Люксембург, Австрали, АНУ болон Канад зэрэг улсын олон иргэн миний лекцийг чих тавин сонсож, санал бодлоо илэн далангүй хуваалцаж, мөн чухал асуулт тавьж байсны үндсэн дээр энэ ном маань бүтсэн гэдгийг хэлэхэд таатай байна. Төрөл бүрийн гарал үүсэлтэй, нийгмийн бүх давхарга, нас, хүсийг төлөөлсөн энэ хүмүүст би хязгарагүй их талархаж явдаг билээ.

Энэ ном нь “Эммай тосгон орох замд таараздсан үл таних хүн” гэдэг эхний номын сайжруулсан хувилбар бөгөөд бүхлээрээ тэр бүтээл дээр суурилсан гэдгийг хэлэх нь зүйтэй. Эхний номыг бүтээлцэхэд гар бие оролцсон хүмүүс энэхүү хоёрдахь номон дээр ч хүчин зүтгэсэн юм. Үүнд: зураач Матай Элми, Эйда Бигз, Дон Долтон болон Иэн Мастин нар; мөн Goodseed байгууллагын ажилчид болон өөр олон хүнийг дурдаж болно. Үүнээс гадна энэ номын хавтсыг бүтээсэн Мич Кэри, Жим Маккали болон Скот Маггий нарт бас талархлаа илэрхийлж байна.

Энэ номыг бүтээлцэхэд цаг зав төдийгүй авьяас чадвараа харамгүй зориулсан дараах хүмүүст чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье.

Энн Абейсекера, Бев Алфред, Рэйчэл Бэйдэр, Барипаул, Кристийн Бервик, Корри Брэмсэн, Пууль Брэмсэн, Дерек ба Шанталь Чен, Чарльз ба Кэрол Клаф, Жон Куک, Андрей Кросс, Дэвид Кросс, Пууль ба Кэтлин Хамфрийз, доктор Жаяакумар, Трой ба Наоми Жонстон, Жон Жанкерс, Ричард ба Энн Ноулз, Жон Крайэк, Кийт Крелл, Рожер ба Рене Лоуз, Том Легер, Жули Ланди, А. Пууль Мартин, Чак ба Конни Матиас, доктор Марк Макдоноф, Ричард ба Керри Накамура, Гаэтан ба Айви Пilon, Стийвен С. Т. ба Антуанет Премкумар, Понниа Д. Премнат, ахмад Аль Райтель, Р. Сарма Ракеш, Мохит Рамамоорти, Ллойд Рёдель, Дэвид ба Мириам Шарц, Р. Бирла Рави Шанкер, Акилан Сиванатан, Расс Смит, Уильям Цуи, Т. Витиянандан, Кристи Уайтфорд, доктор Уэйн Уитборн, доктор Карл Уиланд, Кен Вудбридж.

Эцэст нь надтай гучин жилийн турш ханилсан эхнэртээ асар их талархсанаа илэрхийлмээр байна. Тэр маань цуцалтгүй хөдөлмөрлөж, манай багийн бүрэн эрхт гишүүн болж чадсан. Түүний дэмжлэг туслалцааг үнэлээд баршгүй юм.

Энэхүү номыг би өөрийн эхнэр Жэнис И. Кросст зориулав.

# Агуулга

---

	Талархал . . . . .	iii
	Оршил . . . . .	vii
<b>1-р бүлэг</b>	1. Хосгүй нэгэн ном. . . . .	11
	2. Сургалтын зарчим. . . . .	13
	3. Дөчин зохиогчтой ном . . . . .	15
	4. Боловсрол. . . . .	18
	5. Яахвээх . . . . .	20
	6. Ертөнцийн Эзэний ер бусын илэрхийлэл . . . . .	26
<b>2-р бүлэг</b>	1. Эхлэл. . . . .	31
	2. Амьд Оршихуй. . . . .	34
	3. Ер бусын элчүүд болон одод . . . . .	36
<b>3-р бүлэг</b>	1. Үгээрээ л бүтээв ... . . . . .	43
	2. Гурван мөн чанар . . . . .	45
	3. Эмх цэгц ба хууль . . . . .	49
	4. Төгс төгөлдөр ба халамжтай . . . . .	55
	5. Ертөнцийн Эзэнтэй ижил төстэй. . . . .	57
	6. Их дээр оршдог ч бас ойрхон . . . . .	60
<b>4-р бүлэг</b>	1. Хоёр зам . . . . .	69
	2. Туршилт . . . . .	74
	3. Сонголт . . . . .	78
	4. Чи хаана байна? . . . . .	81
	5. Үхэл . . . . .	85
<b>5-р бүлэг</b>	1. Зөрчилтэй хоёр асуудал . . . . .	97
	2. Хоёр төрлийн өргөл . . . . .	103
	3. Мөнхийн амьдралыг хүртсэн хүмүүсийн жагсаалт 112	
	4. Том усан онгоц . . . . .	115
	5. Сүйрэл . . . . .	121
	6. Будлиан . . . . .	128
<b>6-р бүлэг</b>	1. Итгэл . . . . .	135
	2. Амлалтууд . . . . .	138
	3. Үл итгэлийн хүү . . . . .	141
	4. Ивээл . . . . .	143
	5. Шүүлт . . . . .	146
	6. Амласан хүү . . . . .	149
	7. Юу шаардлагатай вэ? . . . . .	154
<b>7-р бүлэг</b>	1. Израйль ба Иудей . . . . .	159
	2. Египетийн хаан ба Мүшэх . . . . .	162
	3. Гамшиг ба зөгнөл . . . . .	166
	4. Талх ба хурга . . . . .	172
<b>8-р бүлэг</b>	1. Улаан тэнгис . . . . .	177
	2. Талх ба ус . . . . .	179
	3. Арван хууль . . . . .	181
	4. Би өнгөрсөн хүн! . . . . .	191
	5. Байг үл онов . . . . .	195
	6. Алтан тугал . . . . .	201

<b>9-р бүлэг</b>	1. Майхан сүм ..... 207 2. Ивээл эсвэл хараал ..... 213 3. Дагон бурхан ..... 217 4. Зарлагууд ..... 223 5. Баал бурхан ..... 230 6. Цөллөг ..... 233
<b>10-р бүлэг</b>	1. Хэтийн төлөв ..... 241 2. Ер бусын элч ..... 244 3. Олон нэр ..... 249 4. Аврагч ..... 253 5. Усаар угаах ёслол ..... 261 6. Нэгдмэл нэг оршихуй ..... 264
<b>11-р бүлэг</b>	1. Уруу таталт ..... 271 2. Хүч чадал ..... 274 3. Дахин төрөх ..... 278 4. Гэрэл ..... 281 5. Няцаагдсан нь ..... 283 6. Арван хоёр дагалдагч ..... 286 7. Талх ..... 289
<b>12-р бүлэг</b>	1. Төлөвлөгөө ..... 293 2. Ганцхан хаалга ..... 294 3. Мөнхийн зовлон ..... 297 4. Гараад ир! ..... 299 5. Хоёр зам ..... 303 6. Боолууд ..... 307 7. Урvasan нь ..... 311
<b>13-р бүлэг</b>	1. Баривчлагдсан нь ..... 317 2. Шүүгдсэн нь ..... 319 3. Ташуурдуулсан нь ..... 324 4. Цовдлогдсон нь ..... 328 5. Дахин амилсан нь ..... 335
<b>14-р бүлэг</b>	1. Үл таних хүн ..... 345 2. Эммай тосгон орох замд заасан сургаал ..... 348 – Эхлэлээс Вавилоны цамхаг хүртэл – 3. Эммай тосгон орох замд заасан сургаал ..... 359 – Аврахаамаас Дээгүүр өнгөрөх хүртэл – 4. Эммай тосгон орох замд заасан сургаал ..... 365 – Ертөнцийн Эзэний хуулиас майхан сүм хүртэл – 5. Эммай тосгон орох замд заасан сургаал ..... 373 – Ниходэмаас Есүсийн дахин амилалт хүртэл – 6. Шүүх хурлын танхим ..... 382 7. Амьд Оршихуй, Ертөнцийн Эзэний хангамж, амлалт ..... 389
<b>15-р бүлэг</b>	1. Надаас юу хүсэж байна вэ? ..... 395 2. Боломжтой үе ..... 415
<b>Тайлбар</b>	Тайлбар толь ..... 419 Библийг сонгох нь ..... 420 Эх сурвалж ..... 421 Тайлбар ..... 421

Библийн бүх ишлэлийг догол мөрөөс эхэлж, налуу фонтоор бичив. Ишлэлийн зарим хэсгийг харлуулан тодруулснаар утга агуулгыг нь онцолж, ач холбогдол өгсөн болно. Харин нэмэлт тайлбарыг дөрвөлжин хаалтад хийсэн болохыг анхаараарай.

Уг номд багтсан Библийн бүх ишлэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Библийн орчуулгын зарчмын дагуу тусгайлан энэ номд зориулан орчуулсан болно. Монгол хэлээр хэвлэгдсэн өөр Библиэс иш татаагүй болно.

## Оршил

Бид олон янзын шашны тогтолцоотой ертөнцөд амьдарч байгаа билээ. Энэ бүхнийг шашин шүтлэг, итгэл эсвэл буруу урсгал ч гэж хэлж болно. Гэхдээ яаж нэрлэх нь гол биш. Хүмүүсийн итгэдэг зүйлийг үл ойшоож хэрхэвч болохгүй. Хүн төрөлхтний түүхэнд шашнаас үүдэлтэй хэрүүл маргаан, дайн дайжин бишгүйдээ тохиолдож байсан. Өнгөрсөн үед энэ нь тэрүүхэн тэндээ болоод өнгөрдөг байсан бол одоо даяарчлалын эрин үед өөр өөр шашны төлөөлөгчид хоорондоо шахцалдсаны улмаас томоохон хэмжээний мөргөлдөөн үүсэх нь энүүхэнд болжээ.

Бидний хажууд амьдарч байгаа хүмүүс юунд итгэдэг төдийгүй яагаад итгэдэг талаар мэддэг байх нь чухал. Бид тэдэнтэй хэзээ ч санал нийлэхгүй байж болно. Гэхдээ тэдний юунд итгэдэгийг ойлгосон цагт хүлээн зөвшөөрөөгүй ч хүлээн зөвшөөрсөн мэт хүлээцтэй ханддаг болно.

Энэ ном бол Библийн тухай ном. Хэрэв та Библийн сургаалыг чин сэтгэлээсээ ойлгохыг хүссэн олны нэг бол зөв номоо олжээ гэж танд хэллэх байна.

Библийн сургаалыг дамжуулахдаа би аль болох нэг талыг барихгүй хичээсэн. Ингэхэд үнэхээр амаргүй л дээ. Библийг уншсан хэн боловч чимээгүй өнгөрч чаддаггүйд хамаг учир байгаа юм. Гэсэн хэдий ч Библийн утга агуулгыг ойлгомжтойгоор дамжуулахыг оролсоны зэрэгцээ Библийг өөрөөр нь яриулахыг чармайсан. Гэхдээ уншигч танд өөрөө дүгнэлт хийх боломжийг гаргаж өгсөн. Харин итгэх итгэхгүй нь таны хувийн асуудал.

Зарим нь намайг Библийг угаасаа үнэн гэдэг үүдиээс хандаж бичсэн тул нэг талыг барьсан гэж шүүмжилж магадгүй. Гэтэл Библи өөрөө өөрийгөө ийм хэлбэрээр танилцуулдаг учраас надад өөрөөр хийх эрх байгаагүй. Өөрөөр хийсэн тохиолдолд үнэнийг гажуудуулахад хүрэх байсан юм. Библи нь хэлэх гэснээ маш шулуун шударга илэрхийлдэг тул би сургаалынх нь хүчийг сулруулж эсвэл утга агуулгыг нь бүдэг бадаг болгохгүй гэж хатуу шийдсэн юм.

Ингээд энэ номыг уншиж эхэл. Библи бүх цагийн хамгийн сайн борлуулалттай номоор зүгээр нэг шалгараагүй юм шүү. Үүнд шалтгаан бий. Энэ бол үнэхээр сэтгэл эзэмдсэн түүх. Өөрийнхөө төлөө санаа тавьдаг хэн ч байсан энэ түүхийг заавал унших ёстой гэж хэлмээр байна.



“Цангасан нэгэн ирж, мөнхийн амь өгөх уснаас  
үнэгүй хүртсүгэй!” гэж Библид хэлсэн болмой.

Үзэгдэл 22:17

# **1-р бүлэг**

- 1 Хосгүй нэгэн ном.**
- 2 Сургалтын зарчим**
- 3 Дөчин зохиогчтой ном**
- 4 Боловсрол**
- 5 Яахвээх**
- 6 Ертөнцийн Эзэний ер бусын илэрхийлэл**

## 1. ХОСГҮЙ НЭГЭН НОМ.

Хүн төрөлхтний түүхэнд хамгийн их түгэн тархсаны зэрэгцээ хамгийн их маргаан өрнүүлсэн нэгэн ном байдаг. Дэлхийн хүн амын тэн хагасаас илүү нь энэ номын зарчмыг бүхлээр нь эсвэл зарим хэсгийг нь дагадаг хэмээн өөрсдийгөө үздэг. Түүнийг *Ариун Библи* гэдэг. Энэ номыг сурууштай олон сайхан зүйлс агуулсан ач тустай ном гэж хэлэх хүмүүс ч цөөнгүй бий. Энэ бол үнэхээр гайхмаар их тоо. Гэхдээ эдгээр хүмүүс дотроос Библийн хамгийн чухал, үндсэн зарчмуудыг жинхэнэ утгаар нь тайлбарлаж чадах нь тун цөөн байдаг.

Зуун зууны туршид олны дунд хамгийн ихээр түгж ирсэн ном бол Библи гэдгийг эрдэмтэн мэргэд нэгэн дуугаар хүлээн зөвшөөрдөг. Библи бол ... *хүн төрөлхтний түүхэнд хамгийн их ши татагдсан, хамгийн олон тоогоор хэвлэгдсэн, хамгийн олон хэлэнд орчуулагдсан, хамгийн хүчтэй нөлөө үзүүлсэн ном'* ях аргагүй мөн. Хэдийгээр Библи ийм их онцгой ном боловч анхаарлын гадна үлдсэн бүтээл гэж хэлж болно. Уран зохиол судлаачид, оюутан сурагчид хүртэл үл ойшоодог нь үнэн. Тэгсэн мөртлөө хамгийн ихээр түгсэн ном гээд байдаг! Ямар ч уялдаагүй мэт санагдана.

Гэтэл Ариун Библийг хүмүүс яагаад уншдаг вэ? Энэ асуултанд олон янзаар хариулж болох ч үндсэн гурван хариултыг чухалчлах нь зүйтэй.

Юуны өмнө Библид хүний баяр хөөр, аз жаргал, уй гашуу, уйтгар гунигийн тухай өгүүлдэг. Үүнд гэр бүлийн асуудал, эх эцгийн үүрэг хариуцлага, хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх тухай болон ажил олгогч, ажилчдын хоорондын харилцааны асуудал багтдаг. Мөнгөтэй хэрхэн ухаалаг харьцах, хүний авьяас чадвар, цаг хугацааны тухай өгүүлсэн болно. Энэ нь амьдралын талаар ерөнхийн ойлголтыг авах асар их үнэ цэнэтэй эх сурвалж болж өгдөг. Энэ их заавар зөвлөгөөний дийлэнхийг тун ч сонирхолтой түүхээр хүүрнэсэн. Эдгээр түүх нь тоолж баршгүй олон зохиол, киног бүтээх онгод нь болсоор ирсэн.

Хоёрдугаарт үхлийн дараа чухам юу болох тухай Библид их өгүүлсэн. Энэ мэдээлэл хүний хувьд яагаад ийм их ач холбогдолтой гэвэл одооны амьдралаас маань бидний дараагийн амьдрал шалтгаалдаг гэж Библид хэлсэнд оршино. Юу болохыг зүгээр л хүлээгээд суувал үхэл ирсний дараа бүх юм нэгэнт хожимдсон байх болно.

“Би үхсэн л бол үхсэн. Үхлийн дараа юу ч байхгүй!” гэж хэлдэг хүмүүсийг бид мэднэ. Гэвч иймэрхүү үзэл бол эхийн хэвлий дэх ураг, “Төрсний дараа ямар нэгэн амьдрал байгаад би итгэхгүй. Амьдрал харанхуй ч дулаахан энэ хэвлийд л байгаа. Өөр хаана ч байхгүй” гэж байгаатай агаар нэг.

Эхийнхээ хэвлий дэх ураг ингэж хэлбэл үнэхээр тэнэг зүйл болох нь гарцаагүй. Тиймээс энэ амьдралын дараахь ирээдүйн амьдралын тухай өгүүлсэн уг номыг зүгээр сонирхож үзээд, үнэн зөв эсвэл буруу ташаа болохыг нь тунгаах нь яаж ч бодсон ухаалаг алхам болох учиртай.

Гуравдугаарт Библид бичсэн зүйлсийн 27 хувь нь зөgnөl байdag. Өnөөdөr эdgээriйn дийлэнх нь яв цав bielchisэн bайgaag хэлэх ёstoy. Ta одооноос 700 жилийn хойno нэgэн augaa хүnий tөrөх хотыg зөgnөj байna gэed төsөөlөөd үz dэ. Zөgnөldөө tuhain hүnий mэнdlэх хот, gазar нутgiig хэlж bайna gэj үzье. Ogt tанихgүй hүmүүs tanы adil bas l tэр nэgэн augaa их udirdagchiyin tuhай zөgnөj bайna gэj bodьё. Tэd бүgd tuhain үjl явdlyg болохooс nь olon zuun жiliyin өmnө tэр hүnийg яg яmar udmaas tөrөhийg nь hүrtэл bичjэ. Mөn busad hүmүүs ch bas l tүnий amьdral үhliyinх nь talaap nariyvclan zөgnөlөө gэj үzье. Edgэer zөgnөl biellэ oloх xir их magadlalтай bайx baysan b?

Библид энэ бүх зөgnөl хэрхэн bielcэн tүүhийg tэмдэglэн үldэesэн bайдag. Gэhdэe ganц nэg udaa bus, harin маш olon udaa bielcэн tuhaj bichjé. Enэ bol үnэhэer gaihahltay! Edgэer zөgnөliyg өgnsiyl gol shaltaan bol bidniyg “mэл gaihahuulj” ulmaap hүnий amьdral, үhэл ba үhliyin daraah amьdralyn tuhaj hэllэh gэesэн busad zүjlдээ anhaarlyg maanx hantuulaahad chiglэsэн gэj Biiblih xэlsen!

*Ariun Bibli* hэмээх эnэhүү nomыn talaap anhan shatny mэdlэgtэй болoход doorx gurvan shaltaan han galttay үndeslэl болoх учirtay.

*Bibli* hэмээх ug ny nom gэesэн græk bolon latin ugэes garaltay aж. Yүnd яmar ch id shidiyin utga aguuulga baihgxүй. Tэр ch baiitugay Biibiliyin xuudasnaa Bibli gэdэg ug ooerøe nэg ch udaa gardagxүй! Bibli ny bichees gэesэн éngiyin utgatai *Surgaal* hэмээх ugéer ooeriyigøe ilérhixildé. Harin *Bibli* bolon *Surgaal* gэesэн xoëp ugiiyg *Ariun* gэj todotgox ny маш chuhal ach holbogdoltay. *Ariun* gэdэg ug ny “tusgai zorilgotoy, busdaas onцgoy” gэesэн utgatai. Өөrøe hэllbél xosgүй, harcyuuulshgүй gэesэн ug. Iinhüü Biibiliyin tүүhийg tovchlon taniilcuulnsaap enэ nomys jaagaad *Ariun Bibli* buyu ugchilbél *Xosgүй Nom* gэj nэрлэsniyig bүgdéerэ oйlгоно.

## 2. Сургалтын зарчим

Энэхүү номыг үргэлжлүүлэн үзэхийн өмнө суралцах арга зүйгээ тогтооцгоёö. Юуны өмнө энэ номыг би Ариун Библийн талаар багахан мэдлэгтэй уншигчдад зориулж бичсэн билээ. Магадгүй Библийн талаар огтхон ч мэдлэггүй байхыг тань үгүйсгэхгүй. Харин энэ номыг уншиж дуусахад Библи гайхамшигтай утгыг танд илэрхийлнэ гэдэг урам хүчийг аваарай. Энэ номын бүлэг бүрийг анхааралтай уншихын зэрэгцээ үзсэн зүйлсийнхээ утгыг сайтар ойлгосон эсэхэд ямар ч эргэлзээгүй болох ёстай.

Би номондоо сургаалаас олонтаа иш татсан. Ишлэл бүрийг догол мөр гаргаж, бичгийн налуу фонтоор бичиж, ард нь Библийн хаанаас авсныг тодруулсан “хаягийг нь” өгсөн болно. Жишээлбэл:

*Ертөнцийн Эзэний сургаалд өмнө нь бичигдсэн брх үгийг их юм ойлгуулахын тулд бидэнд өгчээ. Учир нь Ертөнцийн Эзэний сургаалд заасан тэсвэр тэвчээр, урам зоригийн тусламжтайгаар бид найдвартай болдог юм.*      Rom 15:4

### Библийн оньсого

Эхлэхийнхээ өмнө Библийг өөртөө маш олон хариултыг агуулсан ээдрээтэй оньсоготой жишин үзье. Бид тэдгээр хариултыг нэг нэгээр нь олж оньсогыг таана. Ингэхдээ хариулт бүрийг зөв зүйтэй олж байгаадаа эргэлзэхгүйн тулд бид дунд сургууль болон их дээд сургуулиудад өргөн хэрэглэгддэг сургалтын үндсэн дөрвөн зарчмыг ашиглана.

### 1. Ач холбогдлын дарааллыг тогтоох зарчим

Шинэ зүйлийг анхлан сурахад хамгийн чухал мэдээлэл өгөхийг нь эхлээд үздэгт нэгдэх зарчим оршино. Жишээлбэл хэрвээ барилгачин хэрхэн барилга барихыг заавал, юуны өмнө хэрхэн бат бэх суурь тавьж, дараа нь ганхашгүй бат бэх хана босгож, улмаар салхи борооноос найдвартай хамгаалах дээврийг хийх гэсэн дарааллаар заах нь ойгомжтой. Доторхи засал, будгийг хойш нь тавих нь мэдээж.


Үүнтэй адил Библид асар олон сэдвийг хөндсөн ч бүгд адилхан ач холбогдолтой байдаггүй. Энэ номонд Библийн хамгийн чухал сэдэв дээр анхаарлаа төвлөрүүлнэ. Ингэснээр Библийг нэн гайхамшигтай ч их энгийн утга агуулгатай ном болохыг бид олж мэднэ.

## 2. Түүхийг өгүүлэх зарчим

Хоёрдахь зарчим мэдрэмжтэй холбоотой. Хүн аливаа түүхийг уншихдаа шууд л аравдугаар бүлгээс эхлээд, зургаа уруу орж, дараа нь хоёрдугаар бүлгийг уншаснаа есдүгээр бүлгээр дуусгадаггүй шүү дээ. Аливаа түүхийн учир утгыг алдагдуулахгүйн тулд эхнээс нь алхам алхмаар ахижс, төгсгөлд нь хүргэдгийг бид мэндн. Энэ нь хэнд ч ойлгомжтой, хялбар мэт санагдавч маш олон хүн Библийг энд тэндээс нь авч, хэсэг хэсгээр нь уншиж, учраа олохoo больдог.

Библийн дийлэнх хэсгийг хүүрнэлийн хэлбэрээр бичсэн тул бид Библийн өөрийнх нь үйл явдлын дэс дарааллыг баримтална. Ингэхдээ бил “ар араас нь хэцэнд өлгөсөн хувцастай” адил эхлээд хамгийн ач холбогдолтой түүхүүдийг авч үзэхдээ дарааллыг тогтоох зарчмыг бас нэгэн зэрэг ашиглана. Энэхүү тойм номонд Библийг бүхлээр нь хамруулах боломжгүй учир Библийн түүхийг өгүүлэх явцад зайд завсар гарагыг сануулья.

Хожим Библийн талаар бүрэн, цогц ойлголттой болсныхоо дараа зайд завсрыг уншигч та өөрөө нөхөж болно. Энэ “хэцэнд” Библийн түүх бүгд багтаагүй ч энд өгүүлсэн бүх үйл явдал нийлээд нэгэн үргэлжилсэн хүүрнэлийн салшгүй хэсэг болж зангилагддаг.



## 3. Математикийн зарчим

Гуравдугаар зарчимд дээрх ойлголтыг багтаасны зэрэгцээ өөр нэгэн ухагдахууныг нэмж оруулсан болно. *Хялбараас эхэлж хүнд рүү явахад аливаа сургалтын зарчим оршино.* Жишээлбэл цэцэрлэгийн хүүхдүүдэд алгебрыг заадаггүй шүү дээ. Тэдэнд алим дээр нэмэх нь алим тэнцүү хоёр алим гэхчлэн тооны хамгийн энгийн үйлдлүүдийг заадаг. Харин дунд сургуульд орсных нь дараа хүүхдүүдэд арай хүндэвтэр  $E=MC^2$  гэх мэт

тооны бодлогуудыг заана. Цэцэрлэгийн насныханд алгебрыг заавал хэрхэвч олигтой үр дүнд хүрэхгүй.

Библи ч мөн адил. Хэрвээ үндэс суурийг нь алгасваас та Библийн талаар хачин гаж ойлголттой болж, бүр будилахад хүрч ч магадгүй юм. Энэ бэрхшээлийг тойрч гарахын тулд бид Библийн түүхийг өмнө нь олж авсан мэдлэг дээрээ суурилж, алхам алхмаар заах болно.

#### **4. Ойлгомжтой хэлбэрээр заах зарчим**

Дөрөвдэх зарчимд хоёр зүйл хамаардаг. Эхнийх нь *тодорхой угсийн утга агуулгатай* холбоотой. Олон зууны туршид үгийн утга өөрчлөгдөж болох ч үгсийнхээ утгыг хатуу барьдаг тогтолцоо Библид өөрт нь бий. Угийнхээ утгыг илэрхийлэхийн тулд Библи өөрөө ямар нэгэн түүхийг өгүүлдэг. Харин бид энэ түүхийнх нь тусламжтайгаар тухайн үгийн жинхэнэ утгыг олж мэддэг. Энэ утгыг өөрчлөх арга байхгүй. Үүн дээр үндэслээд *угнуудийнхээ утгыг сургаал өөрөө тодорхойлдог* хэмээн энэхүү зарчим бидэнд зөвлөдөг.

Хоёрдахь хэсэг тодорхой сэдвийг заах асуудлыг хөнддөг. Жишээлбэл бид шинжлэх ухааны аливаа салбарыг хооронд нь хольж хутгалгүйгээр одон орон судлал, хими, биологи гэхчлэн тус тусад нь үздэг. Анхлан суралцаж буй хүнд нарны аймгийн тогтолцоог эсийн бүтэцтэй хамт заавал будилах нь гарцаагүй. Цоо шинэ эсвэл муухан мэддэг зүйлийг заахдаа багш нэг дор, нэг л сэдвийг заах ёстой хэмээн энэхүү зарчим зөвлөдөг. Бид ч мөн ингэнэ.

Ийнхүү бил энэ дөрвөн зарчмыг хэрэгжүүлснээр Библийн утгыг жинхэнээр нь ойлгож чадах бөгөөд Библийн оньсогын зөв хариултуудыг олно.

#### **3. Дөчин зохиогчтой ном**

Ингэхэд Библи хаанаас гаралтай, мөн хэрхэн яаж бидний гар дээр ирсэн бэ?

Библийг 40 гаруй хүн бичсэн түүхтэй. Эдгээр хүмүүс нийгмийн бүхий л давхаргыг төлөөлж байв. Хаад, цэргийн жанжин, төрийн хүн, эрдэмтэн мэргэд, тариачин, гүн ухаантан, малчин, яруу найрагч, загасчин, ерөнхий сайд, эмч, татвар цуглуулагч гэхчлэн цөөхөн хэдийг л дурдахад энэ. Тэдний бичсэн бүтээл Ази, Африк, Европ гэсэн бүхэл бүтэн гурван тивийг дамнаж,

тансаг орд харш, шорон гяндан, эзгүй цөл эсвэл хот суурин гээд өөр өөр орчин, нөхцөл байдлыг дүрсэлсэн аж. Тэд энэ бүхнийг дайн тулаан, энх тайван цаг, эсвэл зовлон шаналал, мөн баяр хөөр эдлэж байхдаа бичжээ. Тэд үүнийг еврей, арамей гэсэн дорнын хоёр, грек гэсэн өрнөдийн нэг, нийт гурван хэлээр туурвижээ. Тэд 1500 жилийн хугацаанд нийтдээ 66 номыг бичсэн ба тэдгээр номыг нэгтгэснээр Библи хэмээх ариун ном бий болжээ.

**Эдгээр 40 хүн хэзээ ч танил байгаагүй бөгөөд тэд олон зуун сэдвийг хөндсөн ч тэмдэглэн үлдээсэн бүх бүтээл нь эхнээсээ дуустлаа хоорондоо нарийн уялдаа холбоотой, цаг хугацааны хувьд тасралтгүй үргэлжилсэн шинж чанартай болсон.**

Энэ бол үнэхээр гайхалтай. Энэ тухай бодож үзье. Хэрвээ өнөөдөр бүгдээрээ нэг үеийн, ижил мэргэжил боловсролтой, нэг газар нутагт амьдардаг, нэг хэлээр ярьдаг, хоорондоо зөвлөлдөх боломжгүй арван хүнд нэг ижил сэдвийг өгөөд саналыг нь асуувал тэдний санал нийлэх магадлал хир зэрэг байх байсан бол? Ийм магадлал бараг байхгүй гэж итгэлтэйгээр хэлж болно. Гэтэл Библийн хувьд тэс өөр. Энд аравхан хүн ганцхан сэдвийн талаар бичээгүй харин бүхэл бүтэн дөчин хүн асар олон өөр өөр сэдвийн талаар бичсэн түүхтэй. Үнэхээр гайхалтай! Энэ бол Библийг хосгүй буюу ариун бүтээл болгодог хүчин зүйлсийн нэг гарцаагүй мөн.

## **Нэг эх сурвалж**

Хэрхэн ийм болов? Эдгээр хүмүүсийн нэг нь ч өөрийгөө Библид өгөгдсөн мэдээллийн эх сурвалж гэж хэлээгүй. Харин ч тэдний бичиж буулгасан бодол санаа нэг эх сурвалжаас гаралтай бөгөөд бүгдэд нь нэг дуу хоолой энэ бүхнийг хэлж бичүүлсэн гэдгийг нотолж байв.

Тэр цорын ганц эх сурвалжийг олж тогтоохын тулд бид Библийн түүхийн хуудсыг нээж, Библийн эхний таван номыг бичсэн Мүшэх гэдэг хүний тухай үзнэ. Ингээд ойролцоогоор 3500 жилийн тэртээ болсон нэгэн түүхээс эхэльье. Энд Мүшэх өөрийг нь хорвоод мэндлэх үеэр эргэн тойронд нь өрнөж байсан түүхээс өгүүлжээ.

## **Мүшэх**

Мүшэх бол Египетэд 350 жилийн турш боолчлогдож ирсэн 2,5 сая хүн амтай Израйльчууд буюу Еврейчүүд хэмээх боол үндэстний төлөөлөгч байв. Египетийн хаан тэднийг хэт олон болж буйг хараад түгшиж эхэлжээ.

Энэ түүх Египетийн хааны үгээр эхэлдэг.

“Израйлийн ард түмэн хэт их олишрч биднээс хүчирхэг боллоо. Тэдэнтэй өөр аргаар харьцахгүй бол болохгүй нь. Хэрвээ дайн дажин гарвал тэд дайсны маань талд орж бидний эсрэг дайтажс манай нутгаас зугтажс магадгүй.”

Тиймээс Египетчүүд Израйльчуудыг хүнд хүчир ажлаар дараахын тулд тэдний дээр харгис харгалзаж нарыг тавив. Гэвч тэднийг хэдий чинээ дарамтлах тусам тэд төдий чинээ олон болжс улам ихээр тархав. Египетчүүд айдаст автаж тэднийг боолын ажлаар хайр найргүй дарав.

Чөлөөлөгдсөн нь 1:9-13

Боолын хөдөлмөр Израйльчуудын тоог багасгаж чадаагүй тул Египетийн хаан тэдний тоог хязгаарлах өөр нэгэн аргыг сэдэв.

Египетийн хаан хоёр Еврей эх баригчдад хандан “Еврей эмэгтэйчүүдийг эх барихдаа эрэгтэй хүүхэд төрвөл нэн даруй алжс, харин охиод төрвөл амьд үлдээ” гэсэн тушаалыг өгөв.

Дараа нь Египетийн хаан арга мухардахдаа “Шинээр төрсөн Еврей хөвгүүн болгоныг Нил мөрний усанд живуулжс, харин охиодыг нь амьд үлдээ” гэсэн зарлигийг нийт ард түмэндээ буулгав.

Чөлөөлөгдсөн нь 1:15-16, 22

Египетийн хааны тушаал үнэхээр аймшигтай, сэтгэл сэргхиймээр байсан. Гэвч хамгийн хүнд хэцүү нөхцөлд ч амьдрал үргэлжилсээр л байдаг билээ. Библид бичсэнээр нэгэн залуухан Еврей эр, эхнэр авч эхнэр нь:

...хөл хүндтэй болжс хүү төрүүлэв.

Чөлөөлөгдсөн нь 2:2

Египетийн хааны тушаалыг хатуу чанд мөрдөх ёстой байсан тул нялях хүүг Нил мөрөнд живуулж ёстой байв. Гэвч эх нь:

...хүүгээ гурван сарын туриш нуув. Цаашид нуух боломжгүй болмогц нэгэн зэгсэн сагсыг олжс, уснаас хамгаалахын тулд барагшин ба давирхайгаар бүрээд түүнд дотор хүүгээ хийгээд, Нил мөрний эрэг хавийн зэгсэн дунд хөвүүлэв.

Ингэхэд эгч нь дүүд нь юу тохиолдохыг хараад зайдуухан зогсож байв.



Үүний дараахан Египетийн хааны охин усанд орох оор ирсэн бөгөөд шивэгчин нар нь голын эргээр зугаалж байв. Хааны гүнжээ зэгсэн дунд сагс байхыг хараад түүнийг шивэгчинээрээ авчруулав. Сагсыг нээхэд уйлагнаж буй нялх хүү байсан аж. Тэрээр хүүхдийг өрөөвдөж, “Энэ нөгөө Еврейчүүдийн хүүхдүүдийн нэг байна” гэв.

Чөлөөлөгдсон нь 2:2-6

Египетийн хааны охин хүүхдтэй болохыг их хүсдэг ч хүүсэр эмэгтэй байсан байж магадгүй. Нялх хүүхэд сагсан дотор хөвөөд ирсэн нь түүний эмзэг асуудлыг шийдсэн мэт болов. Мүшэхийн эгч энэ бүхнийг нууцаар ажиглаж байснаа хааны охин сагсыг нээнгүүт гарч ирээд:

“Би танд хүүхдийг тань хөхүүлэх Еврей өрлөг эх олж өгөх үү?” хэмээн асуув.

Чөлөөлөгдсон нь 2:7

Мүшэхийн эгч гүнжид хүүхдийг нь асрах нэгэн боолыг санал болгов.

“Тэг, тэг” гэж гүнж хариулав. Бүсгүй гэртээ гүйн харьж, хүүгийн ээжийг дуудан авчрав.

Хааны охин түүнд “Энэ хүүхдийг гэртээ аваачаад наадад хөхүүлж өг. Би чамд хөлсийг нь төлнө” гэжээ. Ийнхүү ээж нь хүүгээ өөр дээрээ авч асрав.

Чөлөөлөгдсон нь 2:8-9

Мүшэхийн ээж төрсөн хүүгээ өсгөснийхөө төлөө хөлс авч байв!

Ингээж ээж нь хүүгээ гэртээ өсгөжээ. Ээж нь хүүгээ өсөнгүүт хааны охинд аваачив. Хааны охин хүүг үрчилж Мүшэх хэмээн нэрийг өгөв.

Чөлөөлөгдсон нь 2:9-10

Ингэж Мүшэх Египетийн хааны ордонд өсөн хүмүүжжээ.

## 4. Боловсрол

Ариун Библид дараахь үгийг хэлсэн байдаг.

Мүшэх Египетчүүдийн бүхий л эрдэмд бүрэн боловсорсон нэгэн байв ...

Үйл явдал 7:22

Эртний Египетийн соёл иргэншлээс үлдсэн балгас дундуур хальтхан алхахад л уран барилгаас эхлээд, одон орон судлал хүртэл Мүшэхийн олж авсан асар өргөн хүрээний мэдлэгийн цар хэмжээг ухаарах боломжтой. Түүний эзэмшсэн боловсрол амьдралынх нь бүхий л салбарт нэвт шингэчихсэн, бүхнийг нэгэн зэрэг шүтдэг Египетчүүдийн шашинтай холбоотой байсан байж болох юм.

## Ариун номгүй шашин


Эртний Египетчүүд ихээхэн өндөр хөгжсөн шашны тогтолцоотой байсан хэдий ч шашныг нь нэгдмэл байдлаар тодорхойлоход тун бэрх. Тэдэнд ямарваа нэгэн ариун ном эсвэл судар гэж байгаагүй бөгөөд туйлын үнэн хэмээн дээдлэх сургаалгүй байсан ажээ. Хот суурин болгон өөрийн гэсэн төрөл бүрийн эр, эм бурхдыг шүтдэг байв. Тэр байтугай хамгийн ихээр шүтдэг байсан бурхад нь хүртэл цагийн аясаар өөрчлөгднөн солигддог байжээ.

## Нэг бурхан уу, эсвэл олон бурхад уу

Египетчүүд өөрийгөө олон янзаар илэрхийлдэг цорын ганц дээд шүтээнтэй байсан уу, эсвэл зүгээр л олон янзын бурхдыг шүтдэг байсан уу гэдэг нь одоо хүртэл маргааны сэдэв болсон хэвээр.<sup>2</sup> Энэ хоёр үзэл хоёулаа үнэний хувьтай байсан болов уу. Египетчүүд ухааны их өргөн цараатай хүмүүс байсанд эргэлзэх хэрэггүй. Тэд шинэ бурхдыг түвэггүй амархан хүлээн авч хуучин дээрээ нэмж, нэг бурхны мөн чанарыг нөгөөдөхтэй нь нийцүүлж, санал зөрдөг хэдий ч олон шашны бүх түүх домгийг адилхан хүлээн зөвшөөрөхдөө гаралгай хүмүүс байжээ.<sup>3</sup> Ерөнхийдөө Египетчүүдийг асар олон янзын шүтээнтэй байсныг хэн ч үгүйсгэдэггүй. Тиймээс Мүшэх эдгээр тэргүүн зэрэглэлийн бүх эр, эм бурхдыг сайн мэддэг, бас бага зиндааны бүх бурхадтай ч мөн танил байсан байж таарна.

## Нарны бурхан

Эртний Египетчүүд *Raa* хэмээх нарны бурхныг хамгийн дээд шүтээн гэж үздэг байв. Тэд *Raa* бурхныг өөрөө өөрийгөө бүтээсэн төдийгүй бусад бүх эр, эм бурхдыг ч бүх хүн амьтантай хамт бүтээсэн гэдэгт итгэдэг байв. *Raag* заримдаа бурхдын эцэг эсвэл бурхдын бурхан ч гэж өргөмжилдөг байжээ. Түүнийг шонхор шувууны толгойтой, толгойн дээрээ нарыг бэлгэдсэн алтан зээрэнцэгтэйгээр дүрсэлдэг байв.



## Ихээхэн шашинлаг хүмүүс

Египетчүүд бурхдаа маш их дээдэлдэг байсан ч заримдаа тэднээс бас ихийг шаардаж чаддаг хүмүүс байв. Гэхдээ бурхдаа ямагт бүхнээс дээгүүр тавьдаг байсан нь ойлгомжтой. Шившлэг хийх, тарнидах, ид шидийг үзүүлэхээс эхлээд олон нийтийг хамарсан шашны баяр ёслолыг тэмдэглэх гээд амьдралынх нь бүхий л хэсэг шашинд нэвт автагдсан байжээ. Тэр байтугай уран барилгад нь хүртэл бурхдынх нь нөлөө маш хүчтэй шингэсэн байжээ.

## Нэр хүндтэй шашин

Дөрвөн мянган жилийн өмнө Египетчүүдийн амьдралын хэв маяг маш дээгүүр үнэлэгддэг байсан ба шашныг нь хамгийн нэр хүндтэй шашин гэж үздэг байв.

Мүшэх эртний Египетийн өртөнцөд өндөр эрдэм мэдлэгийг эзэмшсэн ч Еврейчүүдийнхээ зан заншлыг бас сурсан байв. Төрсөн эх нь хүмүүжүүлэн өсгөхдөө хүүдээ өөрийн итгэлийг өгсөн нь эргэлзээгүй.<sup>4</sup> Энэ хоёр итгэл хоорондоо илт зөрчилдэж байсан ч Египетчүүдийн хувьд энэ нь ямар ч хамаагүй байв. Тэд Еврейчүүдийн дээдэлдэг нэгнийг үл ойшодог байжээ. Учир нь Египетчүүд нэг ч Еврей хүн дээдэлдэг нэгнийхээ нэрийг мэдэхгүй байгааг хараад боолуудын Ертөнцийн Эзэн туйлын ядруухан нэгэн гэж бодсон байж таарна!

## 5. Яахвээх

Мүшэх Египет хүмүүжилтэй байсан ч угсаа гарлаа мартаагүй хүн байлаа.

*Мүшэх өсөжс эрийн цээнд хүрсэнийхээ дараа нэг өдөр ард түмнийхээ дунд очижс тэднийг хэчинээн хүнд хүчир ажил хийж буйг нүдэрээ үзэв. Тэгэхэд өөрийнх нь цус нэгт ахан дүүс болох нэгэн Еврей боолыг Египет харгалзагч зодож байхыг тэр хараав. Мүшэх эргэн тойронд хүнгүй байхыг анзаараад нөгөөг Египет хүнийг цохиж алаад элсэнд булжсээ.*

*Египетийн хаан энэ тухай сонсоод Мүшэхийг алахаар хайсан боловч Мүшэх түүнээс зугтажс, Мидяаны нутагт суурьшив. Чөлөөлөгдсон нь 2:11-12, 15*

Зугтаж байсан хүний хувьд Мүшэх өөрийгөө сайтар “далдалжээ”. Тэрээр нутгийн уугуул бүсгүйтэй гэрлээд, мал маллаж сураад хонин сүргийг нь хариулдаг болов.



*Одоо Мүшэх хадам эцэг  
Яйтруугийнхаа мал сургийг хариулж байв... Нэгэн удаа  
тэрээр хонио хариулаад цөлийн гүн рүү нэвтрэв.*

*Чөлөөлөгдсон нь 3:1*

Энэ өдөр Мүшэх маш сонин хачин зүйлийн гэрч болов. Гэнэт гал дүрэлзэж нэгэн бут шатаж эхлэв. Гал хүчтэй дүрэлзэж байсан ч мод өөрөө огт шатахгүй байгааг тэр анзаарав. Үнэхээр хачин жигтэй явдал!

“Хачин юм. Бут яагаад шатаж дуусахгүй байгааг очиж харья байз” гэж Мүшэх дотроо бодов. Чөлөөлөгдсон нь 3:3  
 Түүнийг ойрттол гол дотроос нэгэн дуу хоолой өөрийг нь дуудав.

“Мүшэх ээ! Мүшэх ээ!” Чөлөөлөгдсон нь 3:4

Мүшэхийг хэчинээн их айсныг төсөөлөхөд төвөггүй. Энэхүү шатаж буй бутан дотроос чухам хэн ярьж байв? Нөгөө эр, эм бурхдын нэг байв уу?

Мүшэх, “Би энд байна” гэж хариулав.

Ертөнцийн Эзэн “Наашаа бүү ойрт! Чиний зогсож буй газар ариун учраас хөлөөсөө шаахайгаа тайл” гэж айлдав.

Чөлөөлөгдсон нь 3:4-5



Мүшээх үнэхээр мэгдэж сандарсан байж таарна! Энэ газрыг яагаад ариун гэж хэлэх болов? (Ариун гэдэг нь хосгүй, цорын ганц гэсэн утгатай.) Хэрвээ энэ дуу хоолой нөгөө бурхдын дуу мөн бол яг хэнийх нь байж таарах вэ? Мүшэхийг үг ч дуугарч амжаагүй байхад нөгөө дуу хоолой ахиад л,

“Би бол өвөг дээдсийн чинь Ертөнцийн Эзэн Элухийм байна, мөн Аврахаам, Яйцхаах болон Яахов нарын Ертөнцийн Эзэн байна” гэв.

Чөлөөлөгдсон нь 3:6

## Элухийм

Бурхан гэдэг үг Буддаг эсвэл аливаа өөр шүтэн дээдэлдэг нэгнийг илэрхийлдэг ерөнхий үг бөгөөд ямар ч бурханд хамаатуулж болно. Энэ бол их өргөн утгатай нэр томьёо. Гэтэл энэ дуу хоолой өөрийгөө Мүшэхийн өвөг эцгийн Элухийм гэж хэлээд дараа нь Аврахаам, Яйцхаах, Яахов нарын Ертөнцийн Эзэн гэв. Энэ гурван хүн бол эрт үед нас барсан Мүшэхийн холын хамаатнууд байсан ба боолчлолд орсон Израйлийн ард түмнийг үндэслэсэн хүмүүс байв. Энэ удаад *Raa* бурхан ч биш, Египетийн өөр ямар нэгэн бурхан ч биш, харин боолуудын Ертөнцийн Эзэн шууд л шатаж буй бутан дотроос ярьж байсан нь илэрхий болов.

Мүшэх ээжээсээ Аврахаам, Яйцхаах болон Яахов нартай харилцаж байсан Элухиймийн талаар сонсож байсан ч тэр

тухай бараг мартсан байв. Тэдгээр түүхийг үнэн гэдэгт эргэлздэг хүмүүс ч байсан аж. Үүнээс гадна Египетийн бурхад эгэл жирийн хүнтэй харьцаж хэзээ ч “доошоо ордоггүй” Египетийн эрдэмтэн мэргэд түүнд заасан нь гарцаагүй л болов уу. Бурхад гэдэг нь угаасаа үл хүрэх газар дуу чимээгүй оршдог эсвэл сүмийн зэрэгтэнүүдээр дамжуулан харьцдаг гэж үздэг байв. Гэтэл одоо боолуудын Элухийм шатаж буй бутан дотроос хүмүүс хоорондоо ярьж байгаатай адил шууд л Мүшэхтэй ярив. Энэ Элухийм үнэхээр хосгүй нэгэн байв!

*Мүшиг Элухиймыг үзэхээс айжс нүүрээ гарцаараа таглав.*

*Чөлөөлөгдсөн нь 3:6*

### **Ертөнцийн Эзэн дахиад л ярив:**

*“Би Египетэд байгаа ард түмнийхээ зовлон зудуурийг харсан. Би тэднийг харгис боолчлогчынхoo дарамтаас болж уйлан дуугарч тусламж гүйхыг нь сонссон бөгөөд тэдний байдлыг мэдэжс байна. Би тэднийг Египетчүүдийн савраас чөлөөлжс, тэр газраас гарган суу, зөгийн бал урсах мэт гол мөрөнтий уудам сайхан нутагт аваачихаар бууж ирлээ...*

*Харин одоо замдаа гар. Би чамаар миний ард түмэн Израйльчуудыг удирдуулжс, Египетээс гаргуулахын тулд Египетийн хаан уруу илгээжс байна.”* гэв.

*Чөлөөлөгдсөн нь 3:7-8, 10*

Мүшэхийн зүрх зогсох шахав. Тэрээр зугтаад бүтэн дөчин жилийн нүүр үзэж байв. Египетэд буцаж очих ч дүүрч, харин Египетийн хаан түүнийг өршөөх нь юу л бол. Дэлхийн хамгийн хүчирхэг хүнтэй сөргөлдөж, түүнээс бүх боолоо суллахыг шаардана гэдэг юу гэсэн үг вэ? Үүнээс гадна цус нэгт Еврей ахан дүүс нь түүнийг өөрсдийнхөө төлөөлөгч гэдгийг хүлээн зөвшөөрөх эсэх нь бас л эргэлзээтэй байв.

*Дараа нь Мүшиг Элухиймд хандажс “Хэрвээ би Израйльчууд дээр очижс ‘Та нарын өвөг дээдсийн Ертөнцийн Эзэн намайг илрээлээ, гэхэд өмнөөс ‘Түүний нэр хэн бэ?’ гээж асуувал би юу гэж хариулах вэ?”* гэлээ.

*Чөлөөлөгдсөн нь 3:13*

### **Хүч чадлын асуудал уу?**

Мүшэх яагаад Ертөнцийн Эзэний хувийн нэрийг асуусныг бид үнэхээр мэдэхгүй. Үүний нэг шалтгаан гэвэл хүч чадлын эх сурвалжийн тухай Египетчүүдийн ойлголттой холбоотой байсан байж болох юм. Бурхан бүр өөрийн гэсэн нууц нэрээр хамгаалагдсан янз бүрийн хүч чадалтай байдаг гэдэгт тэд итгэдэг

байв. Тэд ямар нэгэн бурхны нууц нэрийг мэдсэнээр түүний хүч чадал, авьяас чадварыг бас эзэмшдэг хэмээн үздэг байжээ.

Мүшэх Египетчүүдийн олон бурхдын талаар яг дээрх зүйлийг заалгасан байсан тул Еврей боолуудын дээдэлдэг нэгэнд ч бас үүнийг хамаатай гэж бодсон байх талтай. Тэрээр Еврейчүүдийн Ертөнцийн Эзэний нэрийг мэдсэн тохиолдолд Египетийн хаан шиг хүчирхэг хүнтэй нүүр тулахад илүү бэлтгэлтэй болно гэж бодсон болов уу. Гэхдээ энэ нь бас их учиртай. Өөрсдийнх нь бурхад хэзээ ч нэрээ дэлгэдэгүй гэдэгт Египетчүүд итгэдгийг Мүшэх сайн мэдэж байсан. Боолуудын дээдэлдэг нэгэн арай өөр байж магадгүй гэж бодсон уу? Мүшэх чухам яагаад нэрийг нь асуусан шалтгааныг бид үнэхээр мэдэхгүй хэдий ч түүнд өгсөн хариулт туйлын ойлгомжтой байсан юм.

*Тэгтэл Элухийм Мүшэхэд хандажс “Би бол Цорын Ганц Мөнх Оришигч байна. Чи Израйльчуудад өөрийг чинь Мөнх Оришигч явуулсан гээж хэл” хэмээн айлдав.*

*“Та нарын өвөг дээдсийн Элухийм, мөн Аврахаам, Яйцаах болон Яахов нарын Ертөнцийн Эзэн [Яахвээх] намайг та нар уруу илгээсэн гэж тэдэнд дуулга. Энэ бол миний мөнхийн нэр билээ” гээж Ертөнцийн Эзэн Мүшэхэд хэлэв.*

Чөлөөлөгдсөн нь 3:14-15

## Нэр

*Мөнх Оришигч ба Яахвээх<sup>5</sup> гэсэн хоёр нэр эх хэлэндээ ижил утгыг илрхийлдэг.* Тэд хоёулаа цорын ганц *Мөнх Оришихуй* эсвэл хэнээс ч хамааралгүй *Мөнх Оришигч* гэсэн утгатай аж.

Боолуудын Ертөнцийн Эзэн нэрээрээ дамжуулан, өөрийгөө хэнээс ч хамааралгүй, өөрийн хүчээр оршдог хэмээн тунхаглав. Хүнд хоол хүнс, уух ус, гэрэл гэгээ, амьсгалах агаар, унтаж амрах болон толгой хоргodoх байр орон сууц гээд амьдралд нь амин чухал шаардлагатай эцэс төгсгөлгүй их хэрэгцээ байхад энэ Ертөнцийн Эзэн өөрт нь юу ч хэрэггүй гэв. Энэ үнэхээр үнэн байсан бөгөөд түүний жинхэнэ нэр байв. Тэрээр хэнээс ч хамааралгүй өөрийнхөө хүчээр оршдог *Мөнх Оришигч* буюу *Яахвээх* мөн байв. Египетчүүдийн шүтдэг үй олон эр, эм бурхдын нэг нь ч өөрийгөө ингэж тодорхойлоогүй. Боолуудын дээдэлдэг *Яахвээх* үнэхээр хосгүй ажээ!

## Яахвээх

Эртний Израйльчууд *Яахвээхаас* маш их эмээн сүрддэг байсан тул дараагийн хэдэн зууны турш түүний нэрийг ч дурдахаас татгалздаг байв. Сургаалыг чангаар унших үед тэд *Яахвээх* гэдэг нэрийг хэлэх бүрт “*Мөнхийн Эзэн*” эсвэл “*НЭР*” гэж

дууддаг байсан ба үнэн хэрэгтээ энэ үгсээр **Яахвээхийг** хэлж буйг бүгд ойлгодог байв. Мүшэхэд өгсөн Ертөнцийн Эзэний хариултаас харахад өнөөдөр хүртэл **Яахвээхийг** Мөнхийн Эзэн гэдэг үгээр орлуулж бичсэнийг харж болно.

*“Та нарын өвөг дээдсийн Элухийм, мөн А врахаам, Яйцхаах болон Яахов нарын Ертөнцийн Эзэн Яахвээх намайг та нар уруу илгээсэн гэжс тэдэнд дуулга. Энэ бол мөнх өд миний нэр байх болно”* гээж Ертөнцийн Эзэн Мүшэхэд хэлэв.

Чөлөөлгдсөн нь 3:15

Тиймээс Библид Мөнхийн Эзэн гэдэг үгтэй тааралдах бүртээ үүнийг эртний Израйльчуудтай адил ойлгох нь зүйтэй. Үнэндээ та тэр хосгүй Ертөнцийн Эзэний нэр болох **Яахвээх** хэмээн уншиж байгаатай ижил юм. Энэ холбоосыг амархан тогтоож авахад нэмэр болох зорилгоор би заримдаа энэ Ертөнцийн Эзэнийг “**Мөнхийн Эзэн Яахвээх**” гэж бичнэ. Мөн ариун сургаалд **Мөнхийн Эзэн** гэсэн бүх нэр **Яахвээхийг** хэлж буйг санах нь зүйтэй.

Энэхүү хосгүй Мөнхийн Эзэний нэрийг мэдэж авсан анхны хүн бол Мүшэх гэж зарим эрдэмтэд үздэг. Тэрээр **Яахвээх** гэдэг нэрийг бусдад дуулгаж, хүн бүрт мэдүүлэх зорилготой байсан гэдэг. Мөн Египетчүүдийн үй олон эр, эм бурхдаас ялгаатай нь Мөнхийн Эзэн **Яахвээхийн** хүч чадлыг хэн нэгэн хулгайллах аюул огт байгаагүй ажээ.

*Мөнхийн Эзэн Яахвээх минь, тантай адил хэн ч үгүй билээ!  
Та бол аугаа бөгөөд нэр тань төгс хүчтэй юм. Яирматих 10:6*

## Дүгнэлт

1. *Бурхан* гэдэг ерөнхий үг нь *Будда* эсвэл аливаа өөр шутэн дээдэлдэг нэгэн гэсэн утгыг илэрхийлдэг. Библид олон эр, эм бурхдын тухай дурдсан байдаг. Бид Мөнхийн Эзэн **Яахвээх** гэж нэрлэх болно.
2. *Элухийм* гэдэг нь *Ертөнцийн* Эзэн гэсэн утгатай. Түүний нэрийг *Мөнх* *Оришихуй* эсвэл **Яахвээх** гэдэг. **Яахвээх** гэдэг үгээр ихэвчлэн хосгүй, цорын ганц гэсэн утгыг илэрхийлдэг ариун Ертөнцийн Эзэнийг төлөөлөн хэлдэг.
3. Мүшэхээс хойш олон зууны дараа ч гэсэн асар их хүндлэл үзүүлж буйн шинж тэмдэг болгож **Яахвээхийн** нэрийг чангаар хэлдэггүй байсан аж. Бичихдээ хүртэл түүнийг **Мөнхийн** Эзэн гэдэг нэрээр орлуулдаг байв.
4. *Мөнх* *Оришигч* болон *Дээд Нэгэн* гэдэг хоёр нэр ижил утгыг илэрхийлдэг. Хоёулаа хэнээс ч хамааралгүй *Мөнх* *Оришигч* гэсэн утгатай.

## Нэрэнд агуулагдах хүч

Энэ түүх Библид байдаггүй бөгөөд эртний Египетийн домгоос авав. Үүгээр Мүшэхийн үед давамгайлж байсан үзэл бодлыг илэрхийлэв.

Египетийн нарны *Raa* бурхан болон орчлон ертөнцийг бүхлээр нь захирах эрмэлзэлтэй түүний ач охин *Ийса* хэмээх эм бурхны домгоор “хүч чадлын” идшидийг харуулав. *Raагийн* хязгааргүй их хүч чадалд атаархсан *Ийса* түүний нууц нэрийг асуухад тэр хэлэхээс татгалзав. Үүний дараа *Ийса* хорт могой бүтээж *Raагийн* зам дээр тавив. *Raa* тэнгэр дээгүүр аялахдаа нөгөө могойн дээр гишгэж аймшигтайгаар хазуулав. Түүнийг тэвчихгүй хашгирахад бусад эр, эм бурхад туслах гэсэн боловч өвчнийг нь хэн ч эдгээсэнгүй.



Эцэст нь *Ийса* гарч ирээд, *Raag* нууц нэрээ хэлбэл эдгээхээ амлав. *Raa* нэрээ хэлэх дургүй байсан ч өөр сонголт үлдээгүй тул аажим аажмаар нэрээ дэлгэж эхлэв. Өөрийг нь мэхлэхийн тулд *Raa* хуурамч нэрсийг хэлж буйг мэдсэн *Ийса* түүнд итгэсэнгүй. Харин ч тэвчээртэйгээр хүлээв. Эцэст нь *Raa* амь тэмцэхдээ тэсэлгүй жинхэнэ нэрээ *Ийсад* хэлж эдгэрсэн түүхтэй аж.

Ингэсний үр дүнд *Ийса*, *Raатай* эрх тэгш хүчирхэг эм бурхан болсон гэгддэг. Ийнхүү Грекүүд, Ромчууд болон бусад олон үндэстний төлөөлөгчид Тэнгэрийн Хатан Хaan нэрээр алдаршсан *Ийсаг* бурхдын эх хэмээн хүлээн зөвшөөрч шүтдэг болсон аж.

*Raa*, *Яахвээх* хоёрын нэг том ялгаа гэвэл *Мөнхийн* Эзэн *Яахвээх* нэрээ нууцлахыг хүсээгүйд оршино. Харин ч тэрээр нэрийг нь бүх дэлхийд хэлэхийг Мүшэхэд тушаасан. Мүшэх Ариун Библийн эхний таван номыг бичихдээ яг дээрх тушаалыг биелүүлсэн юм.

## **6. Ертөнцийн Эзэний ер бусын илэрхийлэл**

Шатаж буй бутны дэргэд Мүшэх Мөнхийн Эзэн Яахвээхтай нүүр тулгарсан нь ирээдүйд тохиох өөр олон учралын зөвхөн нэг нь л байсан. Мүшэх Библийн 66 номыг бичсэн 40 зохиогчийн хамгийн эхнийх нь байсан ба тэдний нэгээс бусад нь бүгд Израйль хүмүүс байв.<sup>6</sup> Зөвхөн Мөнхийн Эзэн Яахвээх л тэдгээр 40 хүнд нэг дуу хоолойгоор ярьж, сургаалын бүх номыг хооронд нь хосгүй нарийн уялдаатай, цаг хугацааны хувьд тасралтгүй ургэлжилсэн шинж чанартай болгосон.

## Ертөнцийн Эзэний ер бусын илэрхийлэл

Мөнхийн Эзэн, дарга хүн нарийн бичигтээ хэлж буй маягаар Мушэхэд сургаалаа хэлж бичүүлээгүй. Энэ үйл явцыг амьсгаагаа гаргахтай зүйрлэсэн болно.

Ертөнцийн Эзэний бүх сургаалыг хүмүүс бичсэн боловч тэр сургаалын уг үсэг бүрийг Ертөнцийн Эзэн өөрөө амьсгаагаа гаргасан мэт ер бусын илэрхийллээрээ хэлсэн.<sup>7</sup>

2 Тумоюд 3:16

Мөнхийн Эзэн бүхий л сургаалаа нэг амьсгаагаар ер бусын илэрхийллийн дагуу хэлж бичүүлсэн гэдэг ойлголт Библид өөрт нь оршдог. Хүн амьсгаага хамаг байдаг дотроосоо гаргадагтай адил Мөнхийн Эзэн бүхий л сургаалаа өөрийнхөө дотроос нэг амьсгаагаар гаргасан гэж үзэх ёстой. Ертөнцийн Эзэн, түүний сургаал хоёр ямагт салшгүй бөгөөд энэ нь Библийг Ертөнцийн Эзний уг гэж хэлдэх нэг шалтгаан юм.

*Мөнхийн Эзэн Яахвээх аа! Таны уг мөнхийн бөгөөд ганхашгүй бат бөх билээ... Дүүлэл 119:89*

Мөнхийн Эзэн сургаалаа алдаанаас хамгаалахын тулд 40 зарлагадаа алдаанаас зайлсхийх маш энгийн аргачлалыг өгснийг дараачийн бүлгүүдэд үзнэ. Ингэснээр аливаа залилан мэхлэгчид “сургаалыг хуурамчаар үйлдэж” түүнийгээ Ертөнцийн Эзэний үг хэмээн тунхаглахаас энхүү арга хэрхэн сэргийлж ирснийг та өөрөө олж тогтоо чадвартай болно. Харин одоохондоо эдгээр 40 хүн бүгд Ертөнцийн Эзэний ер бусын илэрхийллийн хүчээр бүх сургаалыг бичиж буулгасан гэдгийг ухаарах нь чухал.

## Алдаа мадаггүй бүтээл

Мөнхийн Эзэний сургаалыг анхлан амьтны арьсан дээр (илгэн цаас) эсвэл *papiroс* хэмээх ургамлын ишээр хийгдсэн тусгай цаасан дээр хуйлмал бичээсийн хэлбэрээр бичжээ. Эдгээрийг *гар бичмэлийн эх хувилбар* гэдэг байв.


Гар бичмэлийн эх хувилбурууд нас богинотой байсан тул тэдгээрийг хувилдаг байв. Бүгдийг гараар хийдэг байсан нь мэдээж. Энэ хүмүүс Мөнхийн Эзэний сургаалыг хуулбарлаж буйгаа маш сайн ухамсарлаж байсан бөгөөд энэ нь хүн төрөлхтний түүхэнд хийгдсэн хамгийн том хуулбарлах ажил болсон юм.

Еврей хэлээр бичихдээ “*тэд сургаалыг ямар ч алдаа мадаггүй, зөв зүйтэй хуулж авахын тулд хэчинээн хүнд хэцүү бөгөөд их ажислагаатайг нь үл харгалзан алдаанаас урьчилан сэргийлэх бүхий л боломжтой арга хэмжээг авч байсан. Нэг номонд бичигдсэн бүх үсгийн тоог гаргадаг байсан ба үсгийн дундаж тоог өгдөг байжээ. Үнүүдийн хувьд ч мөн адил нийт тоог нь бас гаргадаг байв.*”<sup>8</sup>

Хоёулаа яг адилхан болсонд эргэлзэхгүйн тулд хуулбар болон эх хувилбар хоёр дээр энэхүү үйлдлийг ижилхэн хийж гүйцэтгэдэг байсан аж.

МЭӨ 100 оны үед бичигдсэн Мөхсөн Тэнгисийн Хуйлмал Бичээсийг МЭ-ний 900 оны үед буюу 1000 гаруй жилийн турш дахин дахин хуулбарлан бичсэн гар бичмэлүүдтэй харьцуулан үзэхэд ялгаа гараагүй нь хуулбарлан бичдэг хүмүүс ажлаа дээд зэргийн нарийвчлалтай хийсний баталгаа болж өгсөн.<sup>9</sup>

**Мөхсөн Тэнгисийн хуйлмал бичээс**



МЭӨ 100 он

**Мөхсөн Тэнгисийн хуйлмал бичээсийг олдохос өмнө байсан эртний гар бичээс**



МЭӨ 900 он

Хуулбар хийсэн  
1000 жилийн турш  
өөрчлөгдөөгүй

“*Манай ард түмний үнэт өв болсон тэдгээр номуудад бид хэчинээн их штэгэлийг өгдөг нь бидний үйлдлээр нотлогддог. Тэр цагаас хойш өчнөөн зуун урсан өнгөрсөн ч тэдгээр сургаал дээр өчүүхнийг нэмэх, авч хаях эсвэл өөрчлөхийг хэн ч зүрхлээгүй юм. Тэдгээр номыг Ертөнцийн Эзэнээс өгөгдсөн хэмээн дээдлэх нь бүх*

*Израйльчуудын хувьд агаар амьсгалахтай ижил билээ”<sup>10</sup> хэмээн Еврей боолуудын удмын хүн МЭ 1-р зууны түүхч Юусээфас ард түмнийхээ тухай ийн дүгнэж хэлсэн юм.*

Сургаалын үг үсгийг ямар нэгэн байдлаар оролдох нь Мөнхийн Эзэнийг өөрийг нь “өдөж” байгаатай ижил гэдэгт тэд үнэхээр итгэдэг байжээ. Бидний өнөөдөр хэрэглэж буй сургаал яг тэр 40 хүний бичсэн сургаал мөн гэдгийг батлах хангалттай олон нотолгоо бий.

## Орчуулга

Гар бичмэлийн эх хувилбаруудыг бүх хуулбаруудтай нь хамт анхандаа еврей, арамей болон грек хэлээр буулгасан аж. Бидний дийлэнх нь эдгээр хэлийг мэдэхгүй учраас сургаалыг олон хэлэнд орчуулах шаардлага гарчээ. Орчуулгын ажил эрт дээр үеэс улбаатай гар бичмэлүүд дээр суурилж байв. Библийн зөгнөлүүдийг амьдрал дээр биелж буйгаар дүрслэхийн тулд сургаалын утга агуулгыг өөрчилж ирсэн байх магадлалтай хэмээн зарим нь ярьдаг. Гэвч Мөхсөн Тэнгисийн хуйлмал бичээсүүдийг олсны дараа түүхийн өнө эртний хуудсуудыг сөхөн харах боломжтой болсноор дээрх зүйл хэзээ ч тохиолдоогүй гэдэг дээр эрдэмтэн судлаачид санал нэгдсэн билээ.

*Өвс хатаж, цэцэг гандах ч бидний Ертөнцийн Эзэний сургаал гандан буурахгүй үүрд мөнхөд үлдэнэ (Яшияа 40:8) гэж Мөнхийн Эзэн хэлж байгаа мэт эртний хүмүүс бичсэн нь их сонирхолтой.*

*Газар тэнгэрийг угүй болтол, бүх зорилго нь биелж дуустал Мөнхийн Эзэний сургаалын үг үсгийн хамгийн жсаахан цэг таслал ч тэр хуулиас [Мүшэхийн бичсэн таван ном] алга болохгүй.*

*Матај 5:18*

## Дөчин жил

Мөнхийн Эзэн Яахвээхийн өөрт нь хэлсэн бүхнийг Мүшэх чухам яг хэзээ, хаана бичсэнийг бид тодорхой мэдэхгүй ч энэ бүхнийг амьдралынхаа сүүлчийн 40 жилийн хугацаанд бичсэнийг мэднэ. Цаашдаа бид түүний амьдралд тохиолдсон зарим нэг үйл явдлыг авч үзнэ. Та Библийг уншихдаа Мөнхийн Эзэний сургаалыг уншиж байна гэдгээ байнга санах ёстай. Бид энэхүү номын тусламжтайгаар Яахвээхтай өөртэй нь биечлэн танилцана гэж хэлсэн. Мөнхийн Эзэн:

*“... та нар намайг хайх бөгөөд чин зурхнээсээ хайвал олно.”*  
*Яицмаях 29:13*

... гэж хэлсэн билээ.

## Библийн бүтцийн талаар

Библийн 66 номын хуудсаар аялахынхаа өмнө Библийн ном бүрийг бүлгүүдэд хувааж, харин бүлэг бүрийг ишлэлүүдэд хуваасан байдгийг мэдэх учиртай. Бас зарим Библид түүхийн танилцуулга, тайлбар, газрын зураг зэрэг олон зүйлийг оруулсан байдаг. Энэ нь их ач тустай байж болох ч эдгээр “нэмэлт” зүйлс нөгөө 40 хүнд илэрхийлж бичүүлсэн сургаал биш гэдгийг сайтар ойлгох ёстай. Энэ нь Библийн агуулгын талаар хүмүүсийн хийсэн тайлбар болохыг анхаараарай.

Ертөнцийн Эзэний сургаал нь Хуучин ба Шинэ гэрээ хэмээх хоёр үндсэн хэсэгт хуваагдсан байдгийг мэдвэл зохилтой. Түүхийн үүднээс Хуучин гэрээг гурван хэсэгт ангилсан болно:

1. Мүшэхийн Хууль: Энэ хэсгийг заримдаа *Tora, Mүшэхийн Номууд* эсвэл *Хууль* гэдэг.
2. Бичээс: *Үүнийг заримдаа Дуулал* ч гэдэг.
3. Зарлагуудын бичсэн сургаал.

Библид тааралдах “Хууль болон Зарлагууд” хэмээх үгээр ойролцоогоор сургаалын гуравны хоёрыг эзлэх *Хуучин* гэрээг бүхлээр нь хамаатуулан хэлдэг. Үлдсэн гуравны нэгийг *Шинэ* гэрээ гэдэг.

## **2-р бүлэг**

- 1 Эхлэл**
- 2 Амьд Оршихуй**
- 3 Ер бусын элчүүд болон одод**

## 1. Эхлэл

Мүшэхэд Библийн эхний таван номыг бичихэд эргээд сургуулийн ширээний ард сууучихсан мэт сэтгэгдэл төрж байсан болов уу. Яахвээх түүнийг явцын дунд, аажмаар сургаж байсан нь гарцаагүй. Тэр үеийн Израйльчууд Яахвээхийн талаар тун бага мэдлэгтэй байсан тул тэдэнд маш ихийг сурах шаардлага байжээ.

### Эхний хэдэн үг

Библийн хамгийн эхний номыг Эхлэл гэж нэрлэв. Эхлэл ном гүн утгатай хэдэн үгээр эхэлдэг.

*Хамгийн эхэнд Ертөнцийн Эзэн Элухийм тэнгэр огторгуй,  
дэлхий ертөнцийг бутээжсэ...*

Эхлэл 1:1

Библи нь Яахвээхийг өмнө нь оршиж байсан эсэх талын хэлэлцүүлгээр эхэлсэнгүй. Мөнхийн Эзэн зүгээр л байж байсан. Тэрээр мөнхөд оршиж ирсэн!


Энэ нь Египетчүүд ба Израйльчуудын хэн хэнд нь гайхалтай санагдсан нь мэдээж. *Raa* бурханд хүртэл эхлэл байсан шүү дээ. Түүнийг өөрөө өөрийгөө бүтээсэн гэж эртний хүмүүс үздэг байв. Гэтэл Яахвээх, өөрийгөө эхлэл төгсгөлгүй мөнхөд оршин ирсэн гэж байдаг. Тэрээр бүх мод ургамал, амьтан адгуус, хүмүүс болон газар дэлхийгээс ч өмнө үргэлж оршин ирсэн аж. Мүшэх ингэж бичив:

*Уулс нурууг бий болохоос ч өмнө, таныг энэ дэлхийн  
бөмбөрцгийг бутээхээс ч өмнө та бол эхлэл төгсгөлгүйгээр  
оршиж ирсэн Ертөнцийн Эзэн Элухийм мөн билээ.*

Дуулал 90:2

Эртний Египетийн бурхад төрчхөөд цагийн аясаар өтөлж хөгширдөг байсан бол Мөнхийн Эзэнийг өнө мөнх үргэлжлэх өнгөрсөн үэс оршин ирснээр зогсохгүй бүр өнө мөнхөд оршино гэж Библид хэлсэн.

Бид энэ дэлхий дээр зөвхөн хоромхон зуур л амьдрах буюу бие махбодын маань амьдрах хугацаа нэгэнт хязгаартай тул бидний хувьд мөнх орших Ертөнцийн Эзэний тухай үзлийг бүрэн гүйцэд ухаарах амаргүй. Гэхдээ бидний ойлголтонд нэмэр болохуйц зарим нэг харьцуулан үзүүлэх зүйлс байна. Жишээлбэл үүрд мөнх амьдралыг сансар огторгуйтай зүйрлэж болно.



Та гэрлийн  
хурдаар аялж,  
нэг секундэд  
дэлхийг  
долоон  
удаа  
тойрч...

...хоёр секундэд  
сарыг ардаа  
орхиж...

...таван цагийн  
дараа Плутон  
гариг дээр очно.

...дервэн минутад  
Ангарагт хурч...

Нэг минутад 60 секунд байдаг.  
Хэрэв та гэрлийн хурдаар  
аялбал, ганцхан секундэд 300  
мянган километр замыг туулна.  
Тэгвэл нэг минут, нэг цаг, нэг  
өдөр, эсвэл нэг жилд хэчнээн  
хол очихыг төсөөлөхөд ч бэрх!  
Манай гаригт хамгийн ойр  
орших од хүрэхэд 4.3 гэрлийн  
жил шаардлагатай аж. Эдгээр  
жилийн секунд бүрт та 300 мянган  
километрийг туулна гэсэн уг. Энэ  
нь нийтдээ 40,682,300,000,000  
километртэй тэнцэнэ.

Бидний од болсон нар Сүүн  
Зам хэмээх галактикийн зах  
хязгаарт оршдог. Нарны аймаг  
маань тойргоор эргэлдэх бүх  
гаригстайгаа хамт бухлээрээ энэ  
жижигхэн хайрцагт багтах аж.



## Сүүн Зам<sup>2</sup>

Шөнийн тэнгэрт харагдаг одод нь Сүүн Зам хэмээх үлэмж том оддын гэр бүлийн зөвхөн нэгээхэн хэсэг юм. Гэрлийн хурдаар аялсан ч энэхүү галактикийн нэг захаас нөгөө зах хүрэхэд 100 мянган жил шаардлагатай. Огторгуйд 100 орчим тэрбум галактик байдаг гэсэн тооцоо байдаг бөгөөд эдгээрийн олонх нь тэрбум тэрбум оддоос бүрддэг аж. Галактик нь оддын бөөгнөрөл болон их бөөгнөрөлөөс бүрддэг байна. Бидний орших оддын бөөгнөрөлд хорь орчим галактик байдаг бөгөөд харин оддын их бөөгнөрөлд олон мянган галактик байдаг аж.

### Та од гаригст өөрийнхөө нэрийг өгмөөр байна уу?<sup>3</sup>

Одоо байгаа дэлхийн хүн амын тоон дээр үндэслэвэл, та 16 галактикт нэрээ өгч болох ажээ. Олон тэрбум од таны нэрийг зүүнэ гэсэн уг шүү!

Та гэрлийн хурдаар аялж,  
манайд хамгийн ойр  
орших галактикт хоёр  
сая жилийн дараа хүрч...

...харин хамгийн ойрын  
галактикийн бөөгнөрөлд  
хорин сая жилийн дараа  
очих ажээ.

Харин та  
одоохондоо  
бидний мэдлэгийн  
хүрээнд буй  
орчлон өртөнцийг  
судлах аяллынхаа  
дөнгөж эхэнд явж  
байгаа билээ.

Нарыг тойрон эргэлдэх гариг эрхэс гэхчлэн бид нарны аймгийн талаар тодорхой төсөөлөлтэй болсон байдаг. Огторгуй бол үнэхээр хязгааргүй ч хэзээ ч хүршгүй мэт санагдаж байсан асар холын хэсэгт ч хүрч болохыг сүүлийн үеийн сансрын судалгаанууд нотолсон.

Тэгвэл нэг алхам урагшлаад орчлон ертөнцийг хэмжих гээд үзье. Хэрвээ бид сансрын хөлөгт суугаад, гэрлийн хурдаар аялбал нэг секундэд дэлхийг долоон удаа тойрно! Цаашид энэ хурдаараа огторгуйн гүн рүү нэвтэрвэл хоёр секундэд сарыг ардаа орхиж, дөрвөн минутанд Ангарагт хүрч, таван цагийн дараа Плутон гариг дээр очно. Харин тэндээсээ шууд л бидний орших галактикт хүрч чадна.

Тийм ээ, мөнхөд орших гэсэн ойлголтыг бүхлээр нь ухаандаа багтаана гэдэг амаргүй. Манай орчлон ертөнцийн зах хязгааргүйг ч бас бүрэн ухаарахад бэрх. Энэ хоёр ухагдахуун хоёулаа ухаан санаанд багтамгүй ч хоёулаа бодитой. Мөнхийн Эзэн Яахвээхийн мөнхөд орших талаар Библид маш тодорхой хэлсэн. Түүнийг мөнхийн гэж хэлсэн бөгөөд энэхүү мөнх орших хүч чадал нь яах аргагүй түүний мөн чанарын салшгүй хэсэг учраас түүнийг нэрлэдэг олон нэрсийн нэгэнд энэ үгийг ашигласан.

... тэнд Мөнхийн Эзэн Яахвээх - үхэшигүй мөнхийн  
Элухиймийн нэрийг дуудав ...

Эхлэл 21:33

## 2. Амьд Оршихуй

Би нэгэн гэр бүлтэй Библийн тухай ярилцаж байсан юм. Гэнэт нөхөр нь миний яриаг тасалж “Та Ертөнцийн Эзэнийг яг л хүн байгаа мэтээр яриад байх юм” гэж их л гайхширсан дуугаар хэллээ. “Тийм ээ, зөв. Яг үнэн” гэж би хэлээд түүний бодол санааг асуусан юм.

Тэрээр “Би өмнө нь Ертөнцийн Эзэний талаар ингээж хэзээ ч бодож байгаагүй. Би түүнийг зүгээр л нэгэн их хүч байдаг гэж боддог байсан” гэв.

Сургаалд Мөнхийн Эзэн Яахвээхийг зүгээр л нэгэн их хүч, эсвэл ер бусын ухаан гэдгээр дүрслээгүй, харин ч түүнийг өөрийн гэсэн онцлог зан чанартай, амьд нэгэн хэмээн тодорхойлсныг би түүнд тайлбарлаж өгсөн юм.

## Олон нэртэй цорын ганц Яахвээх

Библид хэрэглэсэн Ертөнцийн Эзний хувийн зан чанарыг илрүүлэх аргын нэг бол нэрсээр нь дамжуулан харуулах явдал билээ. Ертөнцийн Эзэн ганцхан нэртэй гэж хэлэхэд буруугүй ч түүнд өөр олон нэр байдаг. Энэ бүх нэр түүний зан чанарын ямар нэгэн талыг илэрхийлэх үүрэг гүйцэтгэдэг. Жишээлбэл **Яахвээхийг** заримдаа **Дээдийн Дээд** нэгэн гэж дууддаг.

*Ингэснээр Мөнхийн Эзэн Яахвээх нэртэй та л ганцаархнаа  
бүх дэлхийн Дээдийн Дээд нэгэн гэдгийг мэдэх болтугай.*

Дуулал 83:18

*Мөнхийн Эзнийг бүрэн эрхт захирагч гэдгийг Дээдийн Дээд гэсэн нэрээр онцлон харуулав. Эртний их үүрнүүдэд хязгааргүй их эрх мэдэлтэй удирдагчид байсантай адил Яахвээх бол бүхий л орчлон ертөнцийн хаан нь юм.*

Эртний Египетчүүд *Raag* бүх бурхдын тэргүүн төдийгүй бусад бүх эр, эм бурхадаа ч өөрөө бүтээсэн гэдэгт итгэдэг байсныг бид мэднэ. Харин Мөнхийн Эзэн Яахвээх бурхдын өнөр өтгөн гэр булийн тэргүүн байсан уу? Түүний мэдэлд өөр эр, эм бурхад байв уу? Эсвэл Яахвээх гэдэг нэр зүгээр л *Ragiiyn* өөр нэгэн нэр байв уу?

Юуны өмнө Яахвээх гэдэг нь *Raa* бурхны өөр нэг нэр биш бөгөөд үүнээс үүдээд өөр ямар ч бурхны нэр биш гэдгийг ойлгох нь маш чухал. Хоёрдугаарт Библид олон эр, эм бурхдын талаар өгүүлсэн байдаг ч тэд Мөнхийн Эзэнээр удирдуулсан бурхдын нэгэн гэр бүл огтхон ч биш юм. Бид энэ түүхийг гүнзгийрүүлэн үзэхдээ бусад бурхад хаана, ямар байр суурь эзэлдгийг мэдэх болно. Харин одоохондоо бид дараахь үнэнийг л мэдэж байхад хангалттай:

*Та бол Мөнхийн Эзэн Яахвээх, үнэн хийгээд амьд Ертөнцийн  
Эзэн Элхийм бөгөөд мөнх өд хaanчлах хаан. Яирмах 10:10*

*Мөнхийн Эзэн Яахвээхийг хаан гэхлээр түүнийг тэнгэрийн заадал хавьд алтаар цутгасан хаан ширээнд заларчихсан нэгэн настай хүн мэтээр төсөөлөгдэж болох юм. Библид Мөнхийн Эзнийг хэээ ч настай хүнтэй зүйрлэж хэлээгүй. Харин түүний хаан ширээний талаар дурдсан байдаг. Гэхдээ үүлэн дунд байгаагаар бус харин Мөнхийн Улс эсвэл Ертөнцийн Эзний орших газар хэмээх төгс төгөлдөр газар байрладаг тухай өгүүлдэг.*

*Мөнхийн Эзэн ер бусын улсад хаан ширээн дээрээ залардаг.  
Дуулал 11:4*

Библид Мөнхийн Эзнийг орших газраасаа бүхнийг удирддаг гэсэн. Бид энэ газрын тухай ихийг мэдэхгүй ч гайхамшигтай сайхан гэдгийг харин мэднэ. Бид Мөнхийн Улсын тухай илүү дэлгэрэнгүйг сүүлд үзнэ.

## Сүнс

Библид Мөнхийн Эзэнийг эр хүйсэнд хамаатуулан хэлдэг. Гэхдээ үүгээр түүнд хүнтэй адил хүйс байdag гэж хэлсэн юм биш. Яахвээх бол *Raa* хийгээд Египетийн бусад бурхдаас тэс өөр. Түүнд тэдэнтэй адил эхнэр хүүхэд байхгүй. Библид дараахь үнэнийг хэлсэн:

*Ертөнцийн Эзэн бол сүнс...*

*Иоган 4:24*

Эртний хүмүүс шүтээнүүдээ хагас амьтан, хагас хүн мэтээр дүрслэх нь элбэг тохиолддог байсан. Харин Яахвээх сүнс учраас түүнийг ийм байдлаар дүрслэх оролдлого хэзээ ч хийгдээгүй. Түүнд махан бие байхгүй тул түүнийг нүдээр харах боломжгүй.

Оршуулгыг авч үзье. Хүний бие авсан дотор хэвтэж харагддаг боловч нөгөө хүн үнэндээ хаана байгаа вэ? Үнэн хэрэгтээ тэр хүн аль хэдийн байхгүй болчихсон. Тэр хүний сүнс аль хэдийн яваад өгчихсөн. Бид хэн нэгнийг хараахдаа зөвхөн түүний гаднахь бие махбодыг л хардаг. Бид түүний жинхэнэ хүн буюу сүнсийг нь олж харж чаддаггүй. Үүнтэй адил Яахвээх сүнс учраас түүнийг олж харах боломжгүй. Гэхдээ түүнд хүнд байдаг бүх зан чанар, онцлог шинж бий.

## Дүгнэлт

Бид дөнгөж эхэлж байгаа ч Мөнхийн Эзэн Яахвээхийн тухай нэлээд хэдэн зүйлийг сурч амжлаа.

Тэр бол зүгээр нэг хоосон, тодорхойгүй хүч биш. Тэр бол мөнхийн нэгэн.

Түүнд бие махбод байхгүй учраас бие махбодын үйл ажиллагаа ч бас байхгүй. Тэр бол сүнс.

Тэр бол бүхнийг захирах бүрэн эрх мэдэлтэй *Дээдийн Дээд* нэгэн.

Эхлэлийн үед яг л ийм байсан бөлгөө...

## 3. Ер бусын элчүүд болон одод

Одоо бид Мүшэхийн бичсэн эхний өгүүлбэрийн дараахь үгсийг үзнэ.

*Хамгийн эхэнд Ертөнцийн Эзэн Элухийм тэнгэр огторгуй,  
дэлхий ертөнцийг бүтээжсээ.*

*Эхлэл 1:1*

Мөнхийн Эзэний анхны их бүтээлийн ажлын үр дүнг сургаалын бүх хуудаснаас харж болно. Та тодорхой мэдээлэл цуглуулаад энгийн асуултын хариуг авч чадах ч үүгээр л бүх

юм хязгаарлагдана. Библийг хүний хязгааргүй их сониуч занг хангахын төлөө бичээгүй. Библи зарим үйл явдлын талаар анхан шатны мэдээллийг өгдөг ч дэлгэрэнгүйгээр задалдаггүй. Энэ бол аргагүй л сүнслэг нэгэний хэрэглэдэг арга мөн билээ.

## Нэрс

Библид сүнсийг олон янзаар нэрлэдэг. Бид тэднийг ихэвчлэн *ер бусын элч* гэдэг ч сургаалд өөр олон нэрийг ашигласан байдаг. Жишээлбэл херуб, сэриф, ер бусын элч нар, тэргүүн ер бусын элч, өглөөний од гэхчлэн. Нэрсийг үргэлжлүүлж болно. Ерөнхийд нь тэднийг *уй олон юмс* эсвэл *одод* гэдэг (энд тэнгэрийн ододтой андуурахгүй байх нь чухал). Эдгээр нь зарим кинонд үзүүлсэн шиг зүгээр нэг хоосон, хийсвэр хүч биш бөгөөд харин ч бодож сэтгэж, мэдрэх чадвартай бодит сүнснүүд юм.

*Та бол цорын ганц Мөнхийн Эзэн Яахвээх. Та л бүх од гариг, тэнгэр огторгүйг бүтээсэн. Түүгээр ч барахгүй энэ дэлхийг далай тэнгистэй бүтээх дээ дотор нь байгаа бүхэнд амь амьдрал хайрласан. Мөнхийн улсад орших ер бусын элч нар таны өмиө бөхийж, таныг хүндэтгэн магтдаг билээ.*

*Нийхмайх 9:6*

Тэд бүгд өөр өөрийн нэртэй байж болох ч *Гаврель, Михаагэл* гэхчлэн цөөхөн хэдийг л Библид дурдсан.

## Үл үзэгдэх ба тоолшгүй олон

Сүнснүүд Мөнхийн Эзэний адил хүний нүдэнд үл үзэгддэг ч тэдэнд хүнтэй адил махан бие байдаггүй. Бид харж чадахгүй ч тэд хaa сайгүй байж байдаг. Зөвхөн Ертөнцийн Эзэний хаан ширээний эргэн тойронд байсан сүнснүүдийг тоолоход хэрэглэсэн үгсээс хараад л тэдний тоо үнэхээр санаанд багтамгүй аж.

*...Намайг харахад Ертөнцийн Эзэний хаан ширээг тойрсон үй олон ер бусын элчийн дуу хоолой сонсогдоо, ...тэнд тоо томижгүй олон олон сая ер бусын элч байв.*

*Үзэгдэл 5:11*

Хэрвээ Мөнхийн Эзэний хаан ширээ Мөнхийн улсад байдал юм бол ер бусын элч нар ч мөн тэнд оршидог гэсэн үг үү? гэсэн асуулт эндээс үүдэн гарч ирнэ. Ер бусын элч нарт хоргodoх орон гэр шаардлагатай эсэх нь ихээхэн маргаантай асуудал мөн. Гэхдээ Библийг бүхлээр нь аваад үзэхлээр ер бусын элч нар Мөнхийн улсад байрладаг байж болох ч тэд орчлон ертөнцийн хаана ч очих чадвартай гэдэг нь харагдах болов уу. Ер бусын элч нар сүнс учраас тэд аливаа сүм, байшин барилга, хад чулуу, мод ургамал эсвэл гол мөрөнд оршдоггүй болохыг Библид маш тодорхой хэлсэн.

Зарц нар

*Библид олон янзын бурхны тухай өгүүлсэн байдгаас харахад ер бусын элч нар нөгөөр эр, эм бурхдын нэг мөн үү? Гэж асуух нь цагаа олсон асуулт байж таарна. Үүнд, үгүй ээ тэд бурхад биш гэсэн энгийн хариултыг өгч болно. Үнэн хэрэгтээ тэд Мөнхийн Эзэн Яахвээхэд үйлчилж, хүслийг нь биелүүлэхийн төлөө бүтээгдсэн сүнснүүд юм. Тэднийг Ертөнцийн Эзэний даалгаврыг биелүүлэх үүрэгтэй сүнснүүд гэдэг.*

*Ертөнцийн Эзэн өөрөөс нь авралыг хүртсэн хүмүүст туслахын тулд ер бусын элч нараа шлээдэг.* Еврейчүүрдээ 1:14

Ер бусын элч гэдэг уг нь эх Грек хэлэндээ элч эсвэл зарц гэсэн утгыг илэрхийлдэг. Мөнхийн Эзэн, өөрөө тэднийг бүтээсэн тул тэд бүгдээрээ түүний мэдэлд байсан бөгөөд Яахвээхийн хэлсэн бүхнийг хийж гүйцэтгэдэг байв.

## Бүтээгч нэгэн бол эзэмшигч нэгэн

Аливааг бүтээсэн нэгэн түүнийхээ эзэмшигч нь байна гэсэн ойлголт өнөө үеийн мөнгөөр хөдөлдөг эдийн засгийн үед утгаа алдсан нь үнэн. Би Папуа Шинэ Гвиней улсын нэгэн омгийнхны тосгоноор алхаж байснаа санаж байна. “Энэ сэлүүр хэнийх вэ? Энэ хэний завь юм бол oo?” гэж намайг асуух бүрт тэд заавал тодорхой зэмшигчийг нь хэлж байсан. Би тэднээс эдгээрийг яг чухам хэн зээмшдэгийг нь хэрхэн мэддэг тухай асуухад тэд үнэхээр гайхсан. Би тэнэг юм асуучих шиг болсон. Тэдний хувьд бүх юм туйлын ойлгомжтой байсан. “Үүнийг хийсэн хүн л эзэмшигч нь байна шүү дээ!” гэж тэд хэлж байв. Бүтээгч нь заавал эзэмшигч байна гэсэн ойлголт энд их хүчтэй үйлчилж байсан билээ.

Нэгэнт л Мөнхийн Эзэн, өөрөө ер бусын элч нарыг бүтээсэн тул тэд түүний эзэмшил байх ёстой гэдэг ойлголт энд ч гэсэн хүчинтэй байсан. Тэд нэгэнт л түүний мэдэлд байсан учраас зарц, элчийнхээ үүргийг үнэнчээр хүлээж, Эзэнийхээ бүх тушаалтыг биелүүлэх ёстой байсан. Гэхдээ эн бол эртний үеийн боолчлолын нэгэн хэлбэр биш. Энд хүчээр ажиллуулах гэсэн ойлголт огт байхгүй. Ер бусын элч наарт үүнээс илүү сайн Бүтээгч Эзэн олдохгүй л байсан болов уу.

## Ер бусын оюун ухаан ба хүч чадал

Мөнхийн Эзэн зорилгоо гүйцэлдүүлэхийн тулд ер бусын элч нарыг онцгой их оюун ухаан, хүч чадалтай бүтээжээ. Тэднийг муу мухай чанаргүй, төгс төгөлдөр хэлбэрээр бүтээсэн ч тэд бас тушаалыг үг дуугүй гүйцэтгэдэг цахим хэрэгсэл биш юм. Тэд бүгд өөрийн сонголтыг хийх чадвартай.<sup>4</sup> Энэ бол их чухал.

Библид ер бусын элч нар ажилдаа гарахынхaa өмнө Мөнхийн Эзэнийг магтдаг байсан тухай олонтаа өгүүлсэн. *Магтах гэдэг үг нь хүний илүү сайн байгааг ярьж, баадан биширснээ илэрхийлэх гэсэн утгатай.*

*Ер бусын элчүүд ээ! Түүний уг бүрийг шүүрэн авч төлөвлөгөөг нь гүйцэлдүүлдэг түүний хүчирхэг ер бусын элч та нар Мөнхийн Эзэнийг магтацаа! Тийм ээ, түүний хуслийг биеүүлэн үйлчилдэг түүний уй олон ер бусын элч та нар Мөнхийн Эзэнд магтаалаа илэрхийлжээ!* Дуулал 103:20-21

Магтаалыг чин сэтгэлээсээ хэлээгүй л бол ямар ч үнэ цэнэ байхгүй. Энд би уй гашууг хуваалцах гэсэн хүний өөр нэгэн сэтгэлийн илэрхийллээр жишээ татаан үзүүлье.

Хэсэг хугацааны турш би хүмүүсийг гашуудлын ёслолд хөлсөөр оролцуулдаг тогтолцоотой нэгэн оронд амьдарч байлаа. Оршуулгын үеэр хэсэг бүлэг хүмүүс тусдаа зогсоцгоогоод, тасралтгүй чангаар эхэр татаан уйлан хашгиралдахыг хараад үнэхээр зүрх зүсэм хэцүү. Тэд ийнхүү аяглацгаан, ажлынхаа төлөө хангарттай шан харамж аваагүй гэж үзсэн тохиолдолд уйлж хашгирахаа нэн даруй зогсоож, чив чимээгүй болдог байв. Тэдний илэрхийлсэн уй гашуу тун бодитой харагддаг байсан ч чин сэтгэлийнх байгаагүй учраас ямар ч утга, үнэ цэнэ байгаагүй.

Хэрвээ ер бусын элч нарт цахим хэрэгсэлтэй адилхан Мөнхийн Эзэнийг магтах хөтөлбөрийг суулгачихсан бол энэ нь бас л дээрх хөлсний хүмүүстэй ижилхэн хий хоосон зүйл байх байсан нь мэдээж. Гэвч тэднийг чөлөөтэй сонголт хийх чадвартайгаар бүтээсэн тул тэдний илэрхийлж байсан баяр хөөр, хайр эсвэл талархал нь бүгд чин сэтгэлээсээ байв. Библид Яахвээхийг магтах гэдэг ойлголтыг ихэвчлэн хүндэтгэх гэсэн ойлголттой холбон үздэг.

*Та бол цорын ганц Мөнхийн Эзэн Яахвээх. Та л бүх од гариг, тэнгэр огторгуйг бүтээсэн. Түүгээр ч барахгүй энэ дэлхийг далай тэнгистэй бүтээх дээ дотор нь байгаа бүхэнд амь амьдрал хайрласан. Мөнхийн улсад ориших ер бусын элч нар таны өмнө бөхийж, таныг хүндэтгэн магтдаг билээ.*

*Нийхмайх 9:6*

## Хүндэтгэл

Хүндэтгэл гэдэг үгэнд хүндлэл хүртэх гавьяатай гэж үзсэн хэн нэгэн хүнд хайр, баадал бишрэлийг үзүүлэх гэсэн утга багтдаг. Энэ нь магтаалын нэг хэлбэр юм. Энэ тохиолдолд ер бусын элч нар Ертөнцийн Эзэнд хүндэтгэл үзүүлж байв.

Мөнхийн Эзэн бүрэн эрх мэдэлтэй Хаан мөн бөгөөд зүй ёсоор өндөр хүндлэлийг хүртэх ёстой байсан тохиолдолд л энэ нь утга учиртай болж ирнэ. Жишээ нь хэрвээ би нэгэн найзынхаа мундгийг гайхаж магтахад хэн нэгэн миний магтаалд эргэлзвэл яах вэ? Харин Библид Мөнхийн Эзэнийг үнэхээр нэр хүндийг хүртэх дээд зэргийн эрхтэй гэж хэлсэн тул ер бусын элч нар бух магтаалаа Яахвээх уруу чиглүүлсэн нь зүй ёсны хэрэг байв. Өөр хэнд ч биш зөвхөн Мөнхийн Эзэнд л хүндэтгэл үзүүлэх ёстой билээ.

*Ертөнцийн аугаа их Эзэн минь! Та бүхнийг өөрийн хүслээр бүтээсэн учраас та бүхий л яруу алдар, нэр хүнд хийгээд бүх чадлыг хүртэх ёстой нэгэн билээ! Мөн таны хүслээр юм бүхэн оршин тогтнодог ажсгуу.*

Үзэгдэл 4:11

## Төстэй ч бас ялгаатай

Хүн оюун ухаан, хүч чадлынхаа хувьд ер бусын элч нарын дэргэд өчүүхэн хэдий ч ер бусын элч нар хүнтэй зарим нэг байдлаараа ижил төстэй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Мөнхийн Эзэн Яахвээх хүнийг ...

*... ер бусын улсын суугчид аас яльгуй доогуур бүтээсэн ...*

Дуулал 8:5

гэж Библид хэлсэн.

Ер бусын элч нар хүнтэй ижил төстэй ч маш их ялгаатай. Тэд хэзээ ч үхдэггүй.<sup>5</sup> Тэд хэзээ ч гэр бүл болж, өсөн үрждэггүй.<sup>6</sup> Тэд хэвийн байхдаа хүний нүдэнд үл харагдах ч зарим онцгой тохиолдолд өөрсдөө үзэгдэн хүнтэй харилцахдаа хэл нь хүнд ойлгомжтой байдаг.

Ер бусын элч нар заримдаа хүмүүстэй ярьдаг тул тэднийг Ертөнцийн Эзэн болоод бусад бурхадтай андуурдаг тохиолдол гардаг тухай Библид хэлсэн. Гэхдээ өмнө нь үзсэнчлэн Мөнхийн Эзэн Яахвээх тэднийг өөрөө бүтээсэн ба тэд Бүтээгч Эзэнээсээ ялгаатай. Ер бусын элч нар бол бурхад ч биш, Мөнхийн Эзэн Яахвээхийн нэг хэсэг ч биш. “Бүтээгч” эсвэл “хийгч” гэсэн ангилалд завини сэлүүр багтдаггүйн адил тэд “Ертөнцийн Эзэний” ангилалд ямар ч хамаагүй. Тэд Ертөнцийн Эзэнээс тэс өөр. Зөвхөн нэг л Бүтээгч Эзэн байгаа бөгөөд бусад нь бүгд түүний бүтээл юм.

Үүрэг	Ангилал	Нэр
Бүтээгч	Мөнхийн Эзэн	Яахвээх
бүтээл	ер бусын элч	Гаврель, Михаагэл

## Тослогдсон ер бусын элч

Хамгийн хүчирхэг, хамгийн ухаантай, хамгийн гоо үзэсгэлэнтэйгээр бүтээгдсэн нэгэн ер бусын элчийг херуб гэдэг байв. Библийн зарим орчуулганд түүнийг шуудл Латин хэлнээс *Луусфэр* хэмээн хөрвүүлсэн байдаг. Гэхдээ эх Еврей нэр нь гэрэл цацуулсан нэгэн эсвэл өглөөний од гэсэн утгыг илэрхийлдэг.

*Аяа, үүрийн гэгээний хүү! Гэрэл цацуулсан од oo!*

Яашаах 14:12

*Гэрэл цацуулсан нэгэн гэж тослогдсон херубыг хэлж байна. Тослогдсон гэдэг үгийн утга нь тусгай үүргийг гүйцэтгэхээр томилогдсон хэн нэгний эсвэл ямар нэгэн юмны дээр тос асган баталгаажуулдаг байсан эртний зан үйлээс гаралтай. Тослох үйлдлийг ихээхэн ариун гэж үздэг байсан тул үүнд хөнгөмсөг ханддаггүй байв.*

*Чи бол тослогдсон хамгаалагч херуб байв. ... чи бүтээгдсэн өдрөөсөө эхлэн өө сэвгүй, төгс төгөлдөр байсан.*

Яахезхээл 28:14-15

Гэрэл цацуулсан нэгний гүйцэтгэх үүргийг хэрхэн тодорхойлсныг харахад тэрээр үргэлж Мөнхийн Эзэний дэргэд байсан аж. Бид яваандаа энэхүү тослогдсон ер бусын элчийн талаар илүү ихийг үзэх болно.

## Ер бусын элч нар гэрчлэв

Мөнхийн Эзэний бүтээлийн аугаа ажил ер бусын элч нарыг бүтээснээр эхлэв. Бүх ер бусын элч өөрийг нь хараад хөөрөн баясаж байхад Дээдийн Дээд нэгэн бүхий л орчлон ертөнцийг бүтээх дараагийн аугаа ажлынхаа гарааг тавив.

*Намайг энэ газар дэлхийн суурийг тавьж эхлэх эд чи хаана байв? Энэ бүхнийг мэддэг бол чи хэлээч. Орчлон ертөнцийн хэмжээ хязгаарыг хэн тогтоов? Хэн энэ бүхний нарийн хэмжилтийг хийв? Газар дэлхийн суурийг юун дээр тавив? Хэн дэлхийн тулах цэгийг тогтоож тулгуун чулууг нь тавив? Тэр үед өглөөний одод [ер бусын элч нар] хамтдаа баярлан дуулцааж, ер бусын элч нар баатар хаширч байсан билээ.*

Иов 38:4-7

# **3-р бүлэг**

- 1 Үгээрээ л бүтээв ...**
- 2 Гурван мөн чанар**
- 3 Эмх цэгц ба хууль**
- 4 Төгс төгөлдөр ба халамжтай**
- 5 Ертөнцийн Эзэнтэй ижил төстэй**
- 6 Их дээр оршдог ч бас ойрхон**

## 1. Үгээрээ л бүтээв ...

Эхлэл номын эхний арван хоёр бүлэгт Библийн талаар нэгдмэл ойлголттой болоход нөлөөлөхүйц маш чухал мэдээлэл багтсан болно. Хэрвээ Библийг бидний өмнө нь ярьсан эвлүүлдэг тоглоомын зааварчилгаа гэж үзвэл эдгээр бүлэгт “Маш анхааралтай уншина уу” гэсэн гарчиг өгөх байсан болов уу.

Мөнхийн Эзэн Мүшэхэд эхлэлийн тухай бичихийг тушаасан гэдгийг бид яг үгчлэн ойлговол зохилтой. Ертөнцийн Эзэн газар дэлхий бий болсон хамгийн анхны өдөр чухам юу болж өрнөсөн түүхийг Мүшэхээр бичүүлсэн юм.

### Нэгдэх өдөр

*Хамгийн эх энд Ертөнцийн Эзэн Элухийм тэнгэр огторгуй, дэлхий ертөнцийг бүтээжээ... Ертөнцийн Эзэн “Гэрэл бий болсугай” гэхэд гэрэл бий болов! Ертөнцийн Эзэн гэрлийг хэчинээн сайхан болохыг хараад ... гэрлийг “өдөр”, харанхуйг “шөнө” гэж ирэлэв. Ингээд анхны шөнө болж өглөө ирснээр эхний өдөр өнгөрөв.*

Эхлэл 1:1, 3-5

Ертөнцийн Эзэн хэрхэн бүтээснийг харцгаая. Мөнхийн Эзэн үг хэлэхэд л гэрэл бий болсон гэж Библид өгүүлсэн. Тэрээр гар хөлөө, эсвэл ямар нэгэн багаж ашиглаагүй. Харин ч:

... Ертөнцийн Эзэний тушаалаар анх орчлон ертөнц бий болсон.

Еврейчүүдэд 11:3

### ... гэж Библид бичжээ.

Аугаа их Яахвээх хэмээх нэгэн бидний нүдэнд үзэгдэх хийгээд үл үзэгдэх бүхнийг үг хэлэхэд л бүтээсэн ажээ!

Мөн нэг анхаарах зүйл нь тэрээр бүхнийг оргүй хоосноос бүтээсэн аж. Хүмүүс бид бас бүтээх чадвартай ч заавал урьдаас бэлтгэсэн түүхий эдээр аливааг бүтээдэг. Бид будаг, бийр, цаас ашиглаж зурдаг. Бид мод, чулуу, тоосго, зуурмагаар байшин барьдаг. Харин Мөнхийн Эзэн бүтээхдээ юу ч ашиглаагүй. Тэр зөвхөн үг л хэлсэн!

“Гэрэл бий болсугай...”

Эхлэл 1:3

... гэхэд гэрэл бий болсон! Ийнхүү нэгдэх өдөр өндөрлөв.

### Хоёрдахь өдөр

Газрыг бүтээсэн эхний өдрийн төгсгөлд хуурай газар гэж байгаагүй, зөвхөн хөлгүй их ус л цалгиж байв. Ингээд хоёрдохь өдөр,

... Ертөнцийн Эзэн “Их усыг хоёр тийш нь зааглаж хооронд нь орон зайд бий болсугай” гэв... Ертөнцийн Эзэн энэ орон зайд “тэнгэр” гэж ирэлэв. Ингээд шөнө болж өглөө ирснээр хоёрдахь өдөр өнгөрөв.

Эхлэл 1:6-8

Энэхүү орон зай нь<sup>1</sup> бидний нэрлэж заншсан *агаар мандалтай* ижил утгатай үг байсан бололтой. Дэлхийн *агаар мандал*, ус хоёр бол энэ гариг дээр амьдрал цэцэглэх боломжтой болгодог олон хүчин зүйлийн зөвхөн хоёр нь билээ.

Анх бүтээгдсэн газар дэлхий өнөөдрийнхөөс өөр байсныг харуулсан анхны шинж тэмдгийг бид хоёрдахь өдрөөс харж байна. Цаг агаар их өөр, нийтдээ дулаахан байсан бололтой. Харин ямар шалтгааны улмаас хүрээлэн буй орчин маань өөрчлөгдж өнөөгийн байдалд хүрсэн тухай бид дараа үзнэ.

## **Гуравдахь өдөр**

Гуравдахь өдрийг эхлэхэд орон зайн доорх их ус, хуурай газар байхгүй үргэлжилсэн далай байв.

*Ертөнцийн Эзэн “Тэнгэрийн доорх их ус нэг газар хуралдан хуурай газар бий болсугай” гэхэд хэлсэн ёсоор нь болов. Ертөнцийн Эзэн үүнийг хэчинээн сайхан болохыг харав... Тэгээд “Одоо газрын хөрсөнд төрөл бүрийн ургамал ургасугай. Зөвхөн өөрийн төрлийг тээж ургах үр үндэстэй өвс ногоо болон зөвхөн өөрийн төрлийг тээж ургах мод бут бий болсугай” гэв. Ертөнцийн Эзэн үүнийг хэчинээн сайхан болохыг харав. Ингээд шөнө болж өглөө ирснээр гуравдахь өдөр өндөрлөв.*

Эхлэл 1:9-13

Гуравдахь өдрийг хоёр хэсэгт хувааж болно. Эхлээд хуурай газар бий болов. Далайн ёроол зарим газраараа доошоо сусны улмаас хуурай газар усны гүнээс гарч ирсэн нь ойлгомжтой. Дараа нь шууд л үр жимсээ гаргасан мод ургамлын ертөнц бий болсныг харж байна. Ертөнцийн Эзэн бүхнийг гүйцэд боловсорч цогцолсон, бүрэн бүтэн хэлбэрээр бүтээсэн тухай Библид өгүүлсэн.

Би нэг удаа энэ сэдвээр хүүхдүүдтэй ярилцсан юм. Би тэднийг таван минутанд багтааж аль болох олон төрлийн үр цуглуулах даалгавар өгөв. Тэд хэдэн хормын дараа өргөстэй өргөсгүй, салхинд хийсч тархдаг, халахаараа хагардаг, зарим нь өчүүхэн жижигхэн, зарим нь том гэхчилэн өчнөөн төчнөөн төрлийн үр атгаад, миний өмнө зогссон байв. Би эдгээр жижигхэн үр болтон хэрхэн ургах талаар ямар их мэдээлэл буюу өвөрмөц шинжийг өөртөө агуулдаг тухай тайлбарлав. Навч нь өргөн байх уу, нарийн байх уу, улаан уу, цагаан уу, иш нь модны иш шиг хатуу байх уу, эсвэл өвс шиг уян хатан байх уу, хэзээ хэрхэн яаж ургах гэх мэт мэдээллийг агуулдаг. Мөн үрэнд хэрхэн үржин олшрох талаар мэдээлэл бас өгөгдсөн байдаг. Энэ бүх нарийн үйл явцын тухай бодохоор үнэхээр гайхалтай. Хүн хэзээ ч ийм юм хийж чадахгүй. Мөнхийн Эзэн Яахвээх

зүгээр л үг хэлснээр бүхий л генетикийн мэдээллийг өөртөө агуулсан, бүрэн гүйцэд боловсорсон өвс ногоо, мод ургамлыг бүтээсэн гэж Библид хэлсэн. Гайхалтайяа!

*Мөнхийн Эзнийн уйлс ямар их аугаа билээ! Тэр уйлсэд нь таларх даг бух эн хичээнгүйлэн суралцдаг.* Дуулал III:2

Бүхнийг бүтээх их ажлыг дангаараа гүйцэтгэсэн. Үүнд өөр бурхад оролцоогүй.

“Би цорын ганц Мөнхийн Эзэн. Надаас өөр ийм нэгэн байх гүй” хэмээн орчлон ертөнцийг бүтээж бухнийг дотор нь байрлуулсан ба газар дэлхийг хий хоосон эмх замбараагүй байгахаар бүтээгдэгүй, харин амьдралыг цэцэглүүлэх ийн тулд бүтээсэн Мөнхийн Эзэн ийнхүү айлдааж байна.

Зөвхөн Мөнхийн Эзэн л бидний нүдэнд үзэгдэх хийгээд үл үзэгдэх бүхнийг бүтээх чадалтай байсан.

## **2. Гурван мөн чанар**

Энэ их хязгааргүй орчлон ертөнцийг бүтээсэн нэгний ер бусын хүч чадлыг ухаарахад, заавал пуужин бүтээгч эрдэмтэн байх шаардлагагүй. Библид Мөнхийн Эзэнийг үүнээс ч илүүгээр *бүхий эс хүчирхэг* гэж тодорхойлсон.

*Бидний Мөнхийн Эзэн бол аугаа бөгөөд асар их хүч чадалтай...* Дуулал 147:5

Мөнхийн Эзэн Яахвээх бүхнээс хүчирхэг төдийгүй *бүхнийг мэддэг*. Түүний оюун ухааны энэ их цар хүрээг бүтээлийнх нь хосгүй нарийн бүтцээс харж болно. Библид ингэж бичсэн байдаг:

*...түүний оюун ухааны цар хүрээ хязгааргүй юм.* Дуулал 147:5

Мөнхийн Эзэний бүтээсэн орчлон өртөнц хил хязгааргүй бөгөөд Аугаа Их Бүтээгч Эзэн бүтээсэн зүйлсээ хүссэн газраа байрлуулсаныг харахад асар уудам газраар аялах чадвар шаардлагатайг ч ойлгоно бизээ. Библид Мөнхийн Эзэн Яахвээхийг ахиадл бидний төсөөлөх чадвараас хамаагүй дээгүүр тодорхойлж, түүнийг *xaa сайгүй, нэгэн зэрэг оршидог* гэж хэлсэн.

“Би зөвхөн ганцхан газар байдал Ертөнцийн Эзэн гэж үү? Би хaa сайгүй байдал Ертөнцийн Эзэн биш бил үү? Хүн надаас нуугдаж чадна гээж үү?” хэмээн Мөнхийн Эзэн тунхаглажс байна. “Би тэнгэр огторгуй, газар дэлхийг дүүргэдэг Эзэн биш бил үү?” хэмээн Мөнхийн Эзэн тунхаглажс байна.

Январь 23·23-24

**Бүхнээс хүчирхэг, бүхнийг мэддэг хийгээд *хаа сайгүй, нэгэн зэрэг оршидог* гэсэн энэ гурван мөн чанарыг Мөнхийн Эзэн Яахвээхаас**

өөр хэн ч эзэмшдэггүй. Энэ гурван мөн чанарыг ямар ч алдаа мадаггүйгээр хослуулсан нэгэн л бидний амьдарч буй энэ нарийн төвөгтэй орчныг бүтээх чадвартай байсан нь ойлгомжтой.

*Тэрээр өөрийн хүчээр бөмбөрцгийг бутээж, мэргэн ухаанаараа дэлхийг байгуулж, оюун санаагаараа огторгуйг тэлсэн билээ.*

Яириаих 51:15

Библид гардаг бусад эр, эм бурхдын нэгэнд ч эдгээр мөн чанарыг хамаатуулан хэлээгүй. Ер бусын элч нар үнэхээр хүчирхэг хийгээд ухаантай ч тэдэнд дээрх мөн чанарууд бас л үгүйлэгдэнэ. Харин бид хэнсэн билээ? Хүмүүн бид иймэрхүү чадварын талаар мөрөөдөх ч хэрэггүй.

Бидний хувьд хамгийн энгийн зүйлийг хийхэд л зайлшгүй хамтын хүч хөдөлмөр шаардлагатай болдог. Жишээлбэл айл бүрт байдаг хамгийн энгийн сандлыг хийх гээд үзье.

*Юуны өмнө төмөр хэрэгтэй. Гэтэл төмрийг хаанаас авах вэ?*  
*Чулуунаас гаргаж авна. Харин яг ямар чулуунд төмөр байдгийг хэн мэдэх вэ?*

Бидэнд төмрийн хүдэр ихээр агуулагддаг чулууг олборлох талаар ихийг мэддэг судлаач, хайгуулч хэрэгтэй болно.

*Шаардлагатай чулууны ордыг олчихлоо гэхэд дараачийн алхам юу байх вэ?*

Дэлбэрэх бодис, уул уурхайн тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг хүмүүс хэрэгтэй болохын зэрэгцээ хүдрийг газрын үнээс гаргаж авдаг уурхайчид хэрэгтэй.

*Төмрийн хүдрийг гаргaaд ирлээ гэхэд та үүгээр сандал хийж чадах уу? Мэдээж чадахгүй. Эхлээд үүнийг хайлуулах шаардлагатай. Та хүдрийг хайлах хэмжээний хүчтэй гол асааж чадах уу?*

Иймээс төмөр хайлуулж, хайлш хийх мэдлэгтэй хүн хэрэгтэй. Тэднийг оллоо гэж бодьё. Гэтэл үүгээр юм дуусахгүй.

Тэд бидэнд зүгээр л нэг бөөн төмөр хайлуулж өгнө. Энэ үе шатанд бид зөвхөн төмрийн гулдмай дээр л хөрснийх нь дараа суух үлдэж байна. Хэрвээ бид жинхэнэ сандал хийе гэвэл энэ бөөн төмрийг элдэж нимгэн хавтанцар болгоод, үүгээр хоолой хийж нугалаад гагнах хэрэгтэй.

*Гагнах гэнэ ээ? Цахилгаан болоод цахилгаан үүсгэх талаар мэдлэгтэй хүн хэрэг болох нь.*

Сандал хийнэ гэдэг их төвөгтэй, нарийн ажил болох нь эндээс харагдаж байна. Гэхдээ бид сандлын хуванцар хэсгүүдийн тухай дурдаа ч үгүй байгаа шүү.

*Бас хуванцар хэрэгтэй юу?* Газрын тосны асуудал хөндөгдөх гэж байх шиг байна. Бодоод үзье. Газрын тосыг олборлоход хэчнээн их хүч хөрөнгө, цаг хугацаа орох вэ? Бодохоос ч сүрдмээр...

Зөвхөн ганцхан сандал хийхэд л энэ шүү дээ! Хамгийн энгийн, хялбархан зүйлийг хийхэд л олон зуун хүний хамтын хүч хөдөлмөр, мэдлэг боловсрол шаардагддаг. Нэг хүн энэ бүхнийг мэдэж, энэ бүхнийг бүтээх ямар ч боломжгүй.

Иймээс бүхнийг мэддэг, юу ч үгүй хоосноос бүтээх чадвартай, бүтээлээ хүссэн газраа байрлуулахын тулд хaa сайгүй нэгэн зэрэг оршдог, Бүтээгч Мөнхийн Эзэний дэргэд ойрхон ч дөхөж очих нэгэн байхгүй. Хүмүүс, бурхад, ер бусын элч нар, сүнснүүд бүгд түүний дэргэд өчүүхэн юм. Энэ Ертөнцийн Эзэн ганцхан л байдаг. Түүнтэй эн зэрэгцэх нэгэн үгүй билээ.

*Аяа, Аугаа Их Эзэн Яахвээх минь! Харагтуун! Та орчлон ертөнцийг аугаа их хүч чадал болон сунгасан мутраараа бүтээсэн. Танд чадахгүй юм гэж үгүй билээ.* Яирмаих 32:17

## Амьд Оршихуй

Мөнхийн Эзэний мөн чанаруудыг бүгдийг нь ижилхэн хэмжээгээр ухаарах бас боломжгүй. Ертөнцийн Эзэнийг бүхнээс хүчирхэг хийгээд бүхнийг мэддэг гэдгийг төсөөлөхөд харьцангуй амархан байж болох ч *хaa сайгүй*, нэгэн зэрэг оршдог гэдгийг нь ойлгоход бэрх байж болох юм. Библид Бүтээгч Ертөнцийн Эзэнийг хaa сайгүй, нэгэн зэрэг, эзэgnэн оршдог гэж бидэнд байнга заадаг.

МЭӨ 10-р зууны үед Израйльчуудыг жолоодогч нэгэн хүн Ертөнцийн Эзэний удирдлагаар эдгээр үгсийг бичжээ:

*Таны сүнснээс би хаашаа зугтах билээ? Таны дэргэдээс би хаашаа зайлах билээ?*

*Намайг тэнгэрийн ноён оргил гарсан ч, доошиоо бууж талийгаачдын гүний гүнд гудсан дээр хэвсэн ч та тэнд байж л байна. Үрийн бүлээн салхиар дээшилэн ниссэн ч, далай тэнгисийн цаад талд гарсан ч таны мутар надад газарчилж, баруун мутар тань намайг чанга тэвэрсэн хэвээр. Би, “Өдрийн гэгээ харанхуй болбол намайг халхлах нь дамжиггүй” гэхэд шөнийн харанхуй ч танд өдрийн гэрэл мэт байдаг тул түнэр харанхуй ч танд саад болохгүй билээ.*

*Дуулал 139:7-12*

Мөнхийн Эзэн *хaa сайгүй*, нэгэн зэрэг оршдог гэсэн ойлголтыг пантеизм хэмээх үзлээс ялгаж үзвэл зохилтой.

Пантеизм гэдэг нь маш их өргөн хүрээтэй ойлголт учраас үүнийг тодорхойлоход амаргүй. Гэхдээ ерөнхийд нь хэлбэл бүхий л байгаль дэлхий нь ганцхан эст нянгаас эхлээд сансар огторгуй хүртэл бүгд бурхны нэг хэсэг буюу бүх юм бурхан гэж үздэг. Энэхүү нийтлэг бурханд сансар огторгуйн зүрх сэтгэл, оюун ухаан эсвэл ухамсар байдаг бөгөөд хүн түүгээр нь дамжуулан, түүнтэй нэгдмэл болох чадвартай гэж сургадаг. Пантеизмын онол ёсоор бурхан бол зүгээр л нэг хийсвэр хүч байдаг аж.

Мүшэх энэхүү пантеист үзлийн зарчмыг хүлээн зөвшөөрдөг байсан байж болох юм. Эртний Египетчүүдийн хувьд бурхад, хүмүүс, амьтан шувууд, шавж, мод усны хоорондын ялгаа маш бүдэг байсан. Тэдний олон бурхны зарим нь хүний биетэй байсан хирнээ амьтан шувууд эсвэл шавжны толгойтой байх жишээтэй. Тэд аливаа биет зүйлийг ярих чадвартай гэдэг байсан ба үүгээрээ тэдгээрт бурхны ямар нэгэн шинж чанарыг өгдөг байв. Бүх юм амьдралын хүчтэй гэж үздэг байв. Жишээлбэл тариачин эрдэнэ шишийг хурааж, гурил болгон бяцлахдаа үнэн хэрэгтээ эрдэнэ шишийн бурхны биеийг бяцалж байгаа хэмээн ойлгодог байв.

### **Бүтээгч, бүтээл хоёрын ялгаа**

Мөнхийн Эзэн бол өөрийнхөө бүтээлээс салангид, тусдаа байдаг гэж Библид хэлсэн. Омгийн хүн завины сэлүүрнийхээ нэгэн хэсэг биш байдагтай адил Мөнхийн Эзэн Яахвээх бол бүтээлийнхээ хэсэг нь биш. Завины сэлүүр эвдэрч хэмхрээд алга болж болох ч энэ нь омгийн хүнд ямар ч нөлөө үзүүлэхгүй. Яагаад гэвэл сэлүүр тэр хүний салшгүй нэгэн хэсэг биш.

Үүн лугаа Яахвээх орчлон ертөнцийг дотор нь байгаа бүхэнтэй хамт бүтээсэн гэж сургаалд заадаг ч орчлон ертөнц бол Мөнхийн Эзэний нэгэн хэсэг биш бөгөөд Мөнхийн Эзэн ч бүтээлийнхээ хэсэг нь биш. Мөнхийн Эзэн Яахвээх хaa сайгүй нэгэн зэрэг оршдог ч бүх юмны дотор байдаггүй бөгөөд бүх юмны нэгэн хэсэг биш. Тэрээр бүтээлийнхээ дээр байдаг агаад бүх бүтээлээ удирдан хянадаг. Бүтээгч Эзэн болон түүний бүтээлийн хоорондын ялгааг Библид маш тодорхой харуулсан. Тэр ялгаа хэзээ ч бүдгэрэхгүй.

Үүрэг	Ангилал	Нэр
Бүтээгч	Мөнхийн Эзэн	Яахвээх
бүтээл	ер бусын элч	Гаврель, Михаагэл
бүтээл	мод ургамал	хус, нарс, таана Г.М.

### 3. Эмх цэгц ба хууль

Үндэстэн болгон дэлхийн үүслийн талаар өөр өөрийн гэсэн ойлголттой байдаг. Египетчүүд газар дэлхийн үүслийн талаар хоорондоо ихээхэн зөрчилддэг дөрвөн янзын түүхтэй байсныг Мүшэх ч мэддэг байсан болов уу. Иймэрхүү буруу зөрүү ойлголт их элбэг тохиолддог. Харин одоо, “Та нарын хэн ч эхлэлийн үед байгаагүй. Тиймээс би худал хуурмаг яриаг зогсоохын тулд газар дэлхий хэрхэн бий болсон тухай үнэн түүхийг өгүүлье. Бүх юм яг ингээж хийгдсэн билээ” гэж Мөнхийн Эзэн хэлж байгаа мэт болов.

*Мөнхийн Эзэн Яахвээх үгсээрээ тэнгэр огторгуйг бүтээж, амьсгаагаараа түмэн олныг бий болгосон.* Дуулал 33:6

*Дэлхий даяараа Мөнхийн Эзэнээс эмээгтүн! Хорвоо ертөнцийн бүхий л оршигчид түүнээс сурдэгтүн! Учир нь түүнийг хэлэнгүүт бүх юм бий болж, түүнийг тушаангуут бүх юм бат тогтсон.* Дуулал 33:8-9

Та энэ тухай нухацтай бодож үзвэл бүхнээс хүчирхэг Ертөнцийн Эзэн яг л нэг ийм хүчийг үзүүлэх чадалтай даа гэж яах аргагүй бодогдоно.

#### Дөрөвдэх өдөр

Яахвээх, орчлон ертөнцийг бүтээх их ажлынхаа эхний өдөр зүгээр үг хэлж гэрлийг бий болгосноор харанхуйн хөшгийг татаж хаясан. Харин дөрөвдэх өдөр Яахвээх гэрэл үүсгэгч биетүүдийг бүтээв.<sup>2</sup> Энэ тухай Мүшэх ингэж бичжээ:

*Тэгээд Ертөнцийн Эзэн Элухийм “Өдөр шөнийн ялгааг харуулж, хоног улирал эсслийн заагийг тогтоож, мөн дэлхий дээр гэрэл гэгээ цацуулахаар тэнгэрийн өргөн уудамд одод эрхэс бий болсугай” гэхэд хэлсэн ёсоор нь болов.*

*Ертөнцийн Эзэн асар том хоёр эрхэсийг бүтээж хүрүү гэрэлтэй том нь өдрийг гэрэлтүүлж, бүдэг гэрэлтэй бага нь шөнийн цагаар асч байхаар болгов. Мөн од гаригийг ч бас бүтээв.*

*Элухийм бүтээлийнхээ онц чанарыг хараад “Сайхан байна” гэжс тунхаглав. Ийнхүү шөнө болж өглөө ирснээр дөрөвдэх өдөр өндөрлөв.* Эхлэл 1:14-16, 18-19

Эртний Египетчүүд нарны бурхан *Raag* биширдэг байсныг бид мэдсэн. Мөн тэд сарны бурхан *Tootyg* бас шүтдэг байв. Нар, сар нь зөвхөн хий эсвэл хад чулуунаас бүрдсэн биетүүд байсныг тэр үеийн хүмүүс мэдэх боломжгүй байв. Харин одоо

Мүшэхээр бичүүлсэн  
Мөнхийн Эзэний үгийг  
харснаар нар, сар бол  
бурхад биш гэдгийг тэд  
ойлгох байсан. Үнэндээ  
нар, сар нь Бүтээгч  
Эзэнээсээ ялгаатай, зүгээр л бүтээгдсэн  
амьгүй биетүүд юм. Мөнхийн Эзэн Мүшэхэд  
хандан ингэж хэлжээ:

*Болгоомжлогтун! Та бүхэн хөх тэнгэр  
өөд ширтэхдээ нар, сар, одод эрхсийг  
олж хараад... тэднийг шутэн биширч  
бүү уруу татаагдаарай!* Заварчилгаа 4:19



Нар, сар хоёрыг хүн мэтээр хүлээн авч шүтэн бишрэх ёсгүй. Тэдэнд оюун ухаан эсвэл мэдрэмж байхгүй. Тэд зүгээр л уул ус, гол мөрний ангилалд багтдаг хий болон хад чулуунаас бүрдсэн амьгүй биетүүд мөн.

Харин Мөнхийн Эзэн Яахвээх бол нар, сарнаас эрс ялгаатай амьд нэгэн. Бүтээгч Эзэнийг бүтээсэн зүйлийнх нь нэг хэсэг гэж андуурахгүй байх нь маш чухал.

*Би бол бүхнийг бий болгож, хөх тэнгэрийг ганцаархнаа  
сунгасан... Мөнхийн Эзэн Яахвээх мөн!* Яашаах 44:24

### Эмх цэгцийг дээдэлдэг Ертөнцийн Эзэн

Яахвээх зөвхөн гэрэл, дулааныг ялгаруулахын тулд нар, сарыг бүтээгээгүй. Харин ч өдөр хоног, улирал, он жилүүдийг зааглан тодорхойлохын тулд тэнгэрийн үлэмж том цагийн үүргийг гүйцэтгүүлэхээр бүтээсэн гэж Библид хэлсэн.

*Тэрээр цаг хугацааг заахын тулд сарыг бүтээсэн агаад  
тогтсон цагт жаргахаа мэддэг нарыг ч бас бүтээсэн билээ.  
Дуулал 104:19*

Орчлон ертөнцийг хэчинээн гайхмаар нарийн үйл ажиллагаатай болохыг эртний хүмүүс мэддэг байсан. Тэд Мөнхийн Эзэнийг эмх цэгцийг эрхэмлэдэг Ертөнцийн Эзэн бөгөөд орчлон ертөнцийг зүй ёсоороо оршин тогтоноход зориулсан зохих дүрэм журам, хуулийг баримталдаг Эзэн гэдгийг амархан олж харж чаддаг байв.<sup>3</sup>

Өнөөдөр бид одон орон судлал, биологи, физик, хими гэхчлэн төрөл бүрийн шинжлэх ухааны тусламжтайгаар бодис зүйн хуулиудыг судалдаг. Бид энэ хуулиудыг байх ёстой зүйл хэмээн үзээд, дэндүү дасчихсан учраас үүнгүйгээр дэлхий

хэрхэн оршин тогтнох тухай хэзээ ч санаа зовдоггүй. Гэтэл хэдхэн хором дэлхийн татах хүч үгүй боллоо гэж төсөөльье. Юу болох вэ? Эмх замбараагүй байдал газар авч, дэлхий дээр үхэл ноёрхоно. Дэлхийн таталцлын хууль бусад бүх хуулийн адил тодорхой зорилготой байдаг. Эдгээр хуулийн ачаар бүх юм аюулгүй, эмх цэгцтэй оршин тогтнодог.

*Их Эзэн бүхнийг бий болох оос ч өмнө мөнхөд оришин байсан төдийгүй бүх юм түүний хүчээр оршин тогтнодог. Холосас 1:17*

Бид эдгээр хуулийг зөн билгийнхээ хүчээр мэдэрдэг. Жишээлбэл бид өндөр хад асганы ирмэгээр явахдаа их болгоомжтой явах нь мэдээж. Учир нь дэлхийн таталцлын хуулийг үл ойшоох нь маш ноцтой үр дагаварт хүргэх аюултай. Хууль байсан цагт заавал үр дагавар байна гэдэгт үүний шалтгаан оршино. Хууль нь аливаа үйл ажиллагааны хүрээ, хил хязгаарыг хатуу тогтоож өгдөг. Хэрвээ та тэр хил хязгаарын хүрээнд байвал танд муу юм болохгүй. Хэрвээ түүний гадна гарвал хохирол амсах нь гарцаагүй.

*Өдөр ч таных, шөнө ч бас таных. Та тэнгэрийн гэрэл хийгээд нарыг тохицуулж, газар дэлхийн бүх хил хязгаарыг тогтоосон.*  
Дуулал 74:16-17

Эдгээр хууль буюу нарийн зохион байгуулалттай бүтэц, эмх цэгцтэй байдал нь Мөнхийн Эзэний мөн чанарын тусгал болдог. Мөнхийн Эзэн Яахвээх бол эмх цэгцийг эрхэмлэж, хууль дүрмийг дээдэлдэг Ертөнцийн Эзэн. Тэрээр туйлбаргүй, замбараагүй биш. Хүн, түүний тууштай, үнэнч мөн чанарт бүрэн итгэлтэй байж болно.

## Тавдахь өдөр

Тавдахь өдөр Ертөнцийн Эзэн төрөл бүрийн далайн амьтад, жигүүртэн шувуудыг бүтээв.

*Тэгээд Ертөнцийн Эзэн Элхуийм “Далай тэнгис үй олон амьтнаар дүүрч, хөх тэнгэрийн өргөн уудмаар нисэх жигүүртэн шувууд бий болсугай” гэжээ. Эхлэл 1:20*

Агаар хийгээд далайд бужигнаж буй энэ түмэн амьтан Мөнхийн Эзэн Яахвээхийн бүтээх чадварын бас нэг илэрхийлэл. Тэрээр ургамлын ертөнцийг бүтээснийхээ адилаар нас бие гүйцсэн амьтдыг бүтээж бий болгов. Амьтан бүрийг хэрхэн өсөн үржих удмын иж бүрэн сантайгаар бүтээжээ.

*Ингээд Мөнхийн Эзэн усанд бужигнах далайн аварга биетнуудийг усны амьтадтай хамт өөр өөрийн төрлийг тээн үржих чадвартай болгон бүтээж, мөн үй олон*

жигүүртэн шувуудыг ч бас өөр өөрийн төрлийг тээн уржих чадвартайгаар бүтээв. Ийнхүү шөнө болж өглөө ирснээр тавдаахь өдөр өнгөрөв.

Эхлэл 1:21, 23

## Төгс төгөлдөр, алдаа мадаггүй ба ариун

Яахвээх орчлон өртөнцийг бүтээсэн өдөр бүрийг дараахь үгээр төгсгөж байсныг Мүшэх ийн бичиж үлдээжээ.

Ертөнцийн Эзэн бүхнийг хэчнээн сайн сайхан болсныг харав.

Эхлэл 1:25

Мөнхийн Эзэн төгс төгөлдөр мөн чанартай учраас энэ нь боломжтой болсон юм. Тэрээр ямар ч өө сэвгүй, туйлын сайн сайхан билээ.

Ертөнцийн Эзэн Элухиймийн зам төгс төгөлдөр билээ ...

Дуулал 18:30

Эртний Египетчүүдийн бурхад бодол санаа, сэтгэлийн хөдөлгөөн ба үйлдлээрээ хүмүүстэй их төстэй байсныг Мүшэх мэдэж байсан байх. Тэд эхнэр хүүхдүүдтэй байсан, тэдэнд холбоотон бөгөөд дайснууд байсан. Тэд туйлын садар самуун амьдралтай байсан агаад хуйвалдаж, мэхэлж, эрх мэдлийн төлөө дайтаж, нэг нэгнийгээ харгис хэрцгийгээр алж хороодог байжээ. Улмаар тэд бусад бурхдаа зөвхөн заль мэх, ид шидээр л захирдаг байсан аж.

Харин Яахвээх бол тэс өөр байв. Түүний мөн чанар ямар ч өө сэвгүй буюу төгс төгөлдөр юм. Тэрхүү төгс төгөлдөр байдлыг нь дүрслэхэд хэрэглэсэн үгсийн нэг бол зөв шударга гэдэг үг юм. Энэ нь шулуун, үнэнч, хүндтэй гэсэн утгатай.

Мөнхийн Эзэн Яахвээхийн үйл хэрэг сүр жавхлантай агаад зөв шударга байдал нь үеийн үед үргэлжлэнэ. Дуулал III:3

Энхүү цэвэр ариун мөн чанар (түүний зөв шударга байдал) зөвхөн Мөнхийн Эзэнд л байдаг. Өөр хэнд ч байдаггүй.

... Ертөнцийн Эзэн Элухийм ариун мөн чанараа зөв шударга байдлаараа узүүлнэ.

Яашаях 5:16

Ариун гэдэг үг хосгүй, цорын ганц, онцгой гэсэн утгатайг бид өмнө нь үзсэн. Дээрх ишлэлийн утгыг дараахь байдлаар илэрхийлж болно:

Хосгүй Ертөнцийн Эзэн маань хосгүй мөн чанараа зөв шударга байдал, чин үнэнч зан хийгээд нэр хүндээрээ дамжуулан үзүүлнэ.

Яашаях 5:16-г утгачлан орчуулав

Ийнхүү бид орчлон өртөнцийг бүтээсэн өдрүүдийг үзэх явцдаа Яахвээхийг үнэхээр хосгүй, цорын ганц гэдгийг олж мэдлээ.

Одоо *ариун* гэдэг тодорхойлолтыг Ертөнцийн Эзэний зөв *шударга* зан чанартай холбож, утгыг нь өргөжүүлье. *Ариун* ба зөв *шударга* хэмээх энэ хоёр үг бараг ижилхэн утгатай гэж хэлж болно. Энэ хоёр үгээр түүний ёс суртахууны төгс төгөлдөр байдлыг илэрхийлдэг.

Бүтээгч Эзэний түйлийн зөв шударга байдалд хэт их ач холбогдол өгч, хэтрүүлнэ гэсэн ойлголт үгүй билээ. Та энэ номыг үргэлжлүүлэн үншихдаа үүнийг ямагт санаж байх ёстой. Энэ бол орхигдуулж үл болох зүйлсийн нэг яах аргагүй мөн. Мөнхийн Эзэн, өөрөө төгс төгөлдөр учраас зөвхөн төгс төгөлдөр бүтээлийг л бий болгож чадна. Түүний бүтээсэн дэлхий цагийн аясаар өөрчлөгдсөн ч эхэндээ бүх юм сайн сайхан байсан! “Энэ бүхэн үнэхээр сайн сайхан байна” гэж Ертөнцийн Эзэн хэлсэн шүү дээ. Эхэн үед юм бүхэн үнэхээр өө сэвгүй, төгс төгөлдөр байжээ.

## Эрт дээр үед бичигдсэн ч үнэн зөв ном

Библи бол шинжлэх ухааны ном биш ч гэсэн физикийн өргөнцийн талаар өгүүлэхдээ туйлын үнэн зөв баримтыг дэлгэсэн байдаг. Энэ сэдвээр олон ном бичигдсэн ч сонирхол татахуйц хэдхэн зүйлийн талаар өгүүлье.

Хэдхэн зууны өмнө л газрыг хавтгай хэлбэртэй гэж үздэг байсан. Библид энэ онол нэг ч удаа гараагүй. Харин ч газар дэлхийг бөмбөлөг хэлбэртэйг харуулсан үгийг ашигласан байдаг.

*Тэрээр газар дэлхийн бөмбөрцгийн дээр хаан ширээндээ залардаг.*

*Яашаах 40:22*

Зарим эртний хүмүүс газрыг нэгэн хатуу суурин дээр тогтдог эсвэл бурхан газрыг тогтоож байдаг хэмээн үздэг байсан. Харин Библид Мөнхийн Эзэн,

*... газар дэлхийг хөлгүй орон зайд тогтоосон.*

*Иов 26:7*

... гэж хэлсэн.

2-р зуунд Птолемей нийтдээ 1022 тэнгэрийн оддын бүртгэлийг гаргасан ба энэ тоо 17-р зуунд Галилейг анхны дуранг (телескоп) нээтэл үнэн зөв хэмээн тооцогдож ирсэн. Тусгай дурангүйгээр зөвхөн 5000 орчим одыг л харах боломжтой ч Библийн хамгийн эхний хуудаснуудаас оддын тооны тухай дараахь үгсийг харж болно:

*... далайн эргийн элсний ширхэг мэт үй олон...*

*Эхлэл 22:17*

Ганцхан зууны өмнө л гэхэд далайн ёроолыг нэгэн үлэмж том аяганы ёроолтой зүйрлэдэг байв. Харин Библид далайн ёроолыг уул нуруу, тал хөндийтэй гэж хэлсэн байдаг.

*... уулын бэл уруудан...*

*Яонаах 2:6*

*Далайн ёроолын хөндий ...*

*Шимүүлийн дээд 22:16*

1800 оны дунд үед Матай Моори гэгч хүн далайгаар аялж далай болон далайн салхины урсгалын талаар олон нээлтийг хийсэн. Тэрээр дараахь ишлэлүүдээс урам зоригоо авч байжээ:

*... далайн жисмээр...*

*Дуулал 8:8*

*Салхи өмнө зүгт үлээснээ хойд зүг рүү эргэж, өөрийн аашаар дахин дахин эргэлдэнэ.*

*Гүн ухаан 1:6*

Дурсгалынх нь хөшөөн дээр түүнийг нэг гартаа далайн зураг атгасан, харин нөгөө гарыг нь Библитэйгээр дүрсэлжээ. Мөн: “Далайн замыг анхлан гаргагч Матай Фонтейн Моори. Далай тэнгис болон салхины хуулийн нууцыг анхлан нээсэн суут судлаач. Тэрээр Ариун Сургаалын Дуулал 8:8, Гүн ухаан 1:6-аас урам зоригийг авав” гэсэн бичээс байдаг.

## 4. Төгс төгөлдөр ба халамжтай

### Зургаадахь өдөр

Зургаадахь өдөр нь Яахвээхийн орчлон ертөнцийг бүтээх их ажлын хувьд оргил өдөр байв. Мөнхийн Эзэн хуурай газрын амьтдыг бүтээж энэ өдрийг эхлэв.

*Ингээд Ертөнцийн Эзэн “Газар дэлхий дээр өөр өөрийн төрлийг тээн үржсэг бүх төрлийн амьтан, хэвлээр явагчид болон араатан амьтад бий болсугай” гэхэд хэлсэн ёсоор нь болов.*

*Ертөнцийн Эзэн өөр өөрийн төрлийг тээн үржсэг янз бурийн амьтан, мал болон хэвлээр явагчдыг бүтээгээд хэчинээн сайхан болсныг нь харав.*

Эхлэл 1:24-25

### Төрөл зүйл

Гурав, тав болон зургаадахь өдрүүдэд ургамалын ертөнц, далайн амьтад, жигүүртэн шувууд болон ан амьтдыг “өөрийн төрлийг тээн үржсих” чадвартайгаар бүтээсэн гэж мэдэгдсэн. “Өөрийн төрлийг тээн үржсих” гэсэн нь ямар утгатай вэ? Энгийнээр хэлбэл энэ нь хонь хургалж, гүү унагалж, харин үнээ зөвхөн тугална гэсэн үг. Төмс тарихад сонгино ургах вий гэж айх шаардлага байхгүй.

Харин үржүүлэлтийн үр дүнд олон янзын үүлдэр бий болдог ч тэд ямагт өөрийн төрлийнх хэвээр үлддэг. Ертөнцийн Эзэн нохойг анх удам зүйн бүрэн цогц өвөрмөц шинжтэйгээр бүтээсэн бөгөөд тэр өвөрмөц шинжийг сайжруулах эсвэл дээр нь нэмэх ямар ч боломжгүй. Бид нохой бурийн удам зүйн өвөрмөц шинжийн хэмжээг сонгон багасгах замаар төрөл бурийн үүлдрийн нохойг гаргаж авдаг. Банхар байна уу, эсвэл сенбернар байна уу, ялгаагүй нохойны удам зүйн өвөрмөц шинжийг багасгасны үр дүнд л шинэ үүлдэр бий болдог. Гэхдээ үүлдрээсээ үл хамааран, нохой нохой чигээрээ л үлдсэн. Нохой өөр төрлийн амьтан болж хувираагүй. Бүх төрөл зүйлийг анхнаас нь хөдөлгөөнгүйгээр, хатуу тогтоосон учраас хөршийнх нь үнээ хурдан морьтой нь нийлээд эрлийзчих болов уу гэж гэдэгт малчин санаа зовох хэрэггүй. Яагаад тэр билээ? Яагаад гэвэл Мөнхийн Эзэн бүхнийг эмх цэгцтэй байлгахын тулд энхүү тогтолцоондоо бодис зүйн хуулиудыг суулгаж өгсөн. Бүх юм энэ хуулиуд дээр тогтдог учир амьдралыг аюулгүй, баталгаатай болгож өгдөг.

### Анхаарал халамж

Яахвээх хэдхэн төрөл зүйлийг бүтээнсээр ургамлын ертөнцийг хязгаарлаагүй. Бид итгэхийн аргагүй олон төрлийн ургамлыг харж нүдээ баясгадаг. Яахвээх,

... биднийг баярлуулах бүхнийг өгөөмрөөр хайрладаг.

1 Тимотод 6:17

### ...гэж Библид өгүүлсэн.

Тааламжтай сайхан дэлхийг бүтээсэн Ертөнцийн Эзэн бол үнэхээр анхаарал халамжтай Ертөнцийн Эзэн мөн. Анхаарал халамж үзүүлэх нь хайрлахын нэг хэлбэр.

Яахвээх бүх ургамал, бүх ан амьтдыг цэнхэр өнгөөр будаж чадах байсан ч тэрээр бүхнийг өөр өөрийн гэсэн үй түмэн давтагдашгүй өнгө зүстэй болгосон. Тэрээр дан ганц өнгийг бүтээгээд зогсохгүй тэр олон өнгийг ялган, баясах чадвартай нүдийг бас бүтээсэн.

Аугаа Их Бүтээгч Эзэн бүх хоол хүнсийг гашуун амттай болгож чадах байсан ч тэгээгүй! Яахвээх маш олон төрлийн гайхамшигтай амтыг бүтээсний зэрэгцээ тэр олон амтыг мэдрэх мэдрэмжийг бидэнд бас өгсөн.

Үүнээс гадна тэрээр цэцгийг анхилуун үнэртэй болгосны зэрэгцээ тэр сайхан үнэрийг үнэртэж, таашаал авах чадвартай хамрыг бас бүтээсэн. Тэрээр бүхнийг муудсан өндөгний үнэртэй болгож чадах байсан. Гэвч энэ бол Ертөнцийн Эзэний бүтээн бий болгох арга барил биш юм.

*Газар дэлхий Мөнхийн Эзэн Яахвээхийн хувиршигүй, энэрэнгүй хайраар дүүрэн.*

Дуулал 33:5

*Хайр бол Мөнхийн Эзэн Яахвээхийн мөн чанарын салигүй нэг хэсэг. Хайрлах нь түүний мөн чанарын үндэс юм.*

1 Дуулал 103:17

### Гэр орон

Эр хүн эхнэр авахаасаа өмнө ирээдүйн сүйт бүсгүйдээ зориулж заавал байр орон сууц барих зан уламжлалтай зарим улс оронд би ажиллаж амьдарч байсан. Байшин барих ажлыг туйлын нягт нямбай гүйцэтгэдэг байв. Үүнийг хараад их сонирхолтой. Уг эрийн санаанд нэг тодорхой бүсгүй байгаа нь илт мэдрэгддэг байв. Үүнтэй төстэйгөөр Библид ингэж хэлсэн:

*... орчлон ертөнцийг бүтээжс бүхнийг дотор нь байрлуулсан ба газар дэлхийг хий хоосон эмх замбараагүй байлгах аар бүтээгээгүй, харин амьдралыг цэцэглүүлэхийн тулд бүтээсэн Мөнхийн Эзэн ийнхүү айлдажс байна.*

Яашяах 45:18

Хосгүй агаар мандлаас өгсүүлээд ёроолгүй далай тэнгис хүртэл, амьдралын хэмнэлийг заадаг тэнгэрийн биетүүдээс эхлээд, ургамал амьтны гайхамшигт ертөнц хүртэл, бүхнийг аюулгүй, баталгаатай болгодог хуулиудаас авахуулаад гоё

сайхан амттай хоол хүнсийг хүртэл, их бага гэлтгүй бүхнийг Мөнхийн Эзэн Яахвээх зөвхөн хүнд зориулж бүтээсэн билээ. Тэрээр хүнд, газар дэлхийг өгөх бэлтгэлээ ийнхүү хангажээ.

*Мөнхийн Эзэн бүх талаараа зөв шударга бөгөөд бутээсэнд  
бүх эндээ хайр энэрлийг үзүүлдэг.* Дуулал 145:17

Мөнхийн Эзэн Яахвээх газар дэлхийг зургаан өдөрт багтааж, өөртэй нь тусгайлан нөхөрлөх нэгэнд зориулж бэлэн болгов.

## 5. Ертөнцийн Эзэнтэй ижил төстэй

## Зургаадахь өдөр (үргэлжлэл)

Ертөнцийн Эзэн “Хүнийг өөрсөдтэйгээх ижил төстэй бүтээцгээе.<sup>5</sup> Тэгээд хүнд далаин загас, агаарт нисэх шувууд, тэжээвэр амьтан, хөрст дэлхий болон тэр дэлхий дээр мөлхөгч бүхнийг захирах эрх мэдлийг өгүүлэх” гэв. Ийнхүү Ертөнцийн Эзэн, өөртэйгээх ижил төстэй эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээв.

Эхлэл 1:26-27

## Ертөнцийн Эзэнтэй ижил төстэй

Ертөнцийн Эзэн хүнийг өөртэйгөө ижил төстэйгөөр бүтээсэн гэж хэлсэн. Энэ ямар утгатай вэ? Эртний Египетчүүд өөрийн хаанаа бурхан гэж үздэг байсан. Бүр ядаж хагас бурхан гэдэг байв. Энэ нь хүн бас бурхан байж болно гэсэн үг үү?

Юуны өмнө бид Мөнхийн Эзэний яг таг хуулбар биш гэдэг нь хэнд ч ойлгомжтой. Бид бүхнээс хүчирхэг биш, бүхнийг мэддэггүй, хaa сайгүй, нэгэн зэрэг оршдоггүй. Харин хүнийг биет зүйлийг тусгадаг тольтой илүү төстэй гэж хэлэх нь зүйтэй болов уу. Гэхдээ хүн өөрөө тэр биет зүйл биш. Энэ нь хүнд Ертөнцийн Эзэнтэй ижил төстэй олон тал бий гэсэн уг.

Мөнхийн Эзэн Яахвээх, өөрөө оюун ухаантай, бодож сэтгэх чадвартай, амьд учраас биднийг ч бас өөрсдийн гэсэн зан араншингтай, онцлог шинж чанартайгаар бүтээсэн. Түүнд бидэнтэй анд найзын холбоо тогтоох зорилго байв.<sup>6</sup>

Яахвээх хүнд өөрийнхөө **мөнх орших** мөн чанарын нэгэн хэсгийг буюу мөнхөд орших сүнсийг өгсөн. Яахвээх хүнтэй мөнхөд найз нөхрийн холбоотой байхыг хүсэв. Сургаалд ингэж өгүүлжээ:

Тэрээр хүний зурх сэтгэлд үүрдийн мөнх гэсэн ойлголтыг  
суулгасан билээ. Гүн ухаан 3:11

Мөнхийн Эзэн Яахвээх төгс төглөдөр, өө сэвгүй ёс суртахуунтай учраас хүнийг ч бас өө сэвгүй бүтээсэн. Бид энэ бүхэн хэрхэн

өөрчлөгдсөнийг хожим үзнэ. Эхэн үед хүн ямар ч гэмгүй мөн чанартай байжээ.

Мөнхийн Эзэн, өөрөө Аугаа Их Бүтээгч Эзэн мөн учраас хүнд ч бас бүтээх чадавхыг хайлажээ. Өөрөөр хэлбэл Мөнхийн Эзэн оюуны чадавхынхаа өчүүхэн хэсгийг хүнд тасалж өгсөн аж. Ингэж хүн Ертөнцийн Эзэний эзэмшдэг оюун ухааныг хүртсэн тул бодож, сэтгэж, улмаар ухаарч ойлгох чадвартай болсон. Энэ бол хүнийг, амьтан адгуусаас ялгах маш чухал чадвар юм. Хүн оюун ухаанаараа Ертөнцийн Эзэнтэй төстэй болсон.

Мөнхийн Эзэн, өөрөө бүхнийг мэдрэх чадвартай учраас хүнийг ч бас **мэдрэмж, сэтгэлийн хөдөлгөөнтэй** болгов. Яахвээх хүнийг сайн сайхныг мэдрээд зогсохгүй түүнийг чин зүрхнээсээ талархах чадвартай болгохыг хүссэн.

Хүнд байдаг маш чухал чадвар бол мэдрэмж юм. Хэрвээ хүн мэдрэмжгүй байсан бол цахим хэрэгслээс юугаараа ч ялгаагүй, бие биендээ хүйтэн хөндий, тооцоотой хандах байсан.

Ертөнцийн Эзэн хүнийг мөн **сонголт хийх** чадвартай бүтээсэн. Өөрөө бие даан шийдвэр гаргах хүний чадварыг байдаг л зүйл хэмээн үздэг ч аливааг сонгож, эрхэмлэх чадвар нь хүнийг адгуус биш харин хүн болгодог хүчин зүйл юм. Өөртэйгөө машин шиг бус, харин жинхэнэ наиз нөхрийн хувьд чөлөөтэй харилцах боломжтой болгохиын тулд Мөнхийн Эзэн хүнд сонголт хийх чадварыг өгсөн.

Энэ бүх чадвар *Ертөнцийн Эзэний мөн чанарын* тусгал юм. Заримдаа үүнийг *Ертөнцийн Эзэний яруу алдар* ч гэдэг. Яахвээх хүнийг өөртэйгөө ижил төстэй бүтээхдээ хүнд өөрийнхөө мөн чанарын өчүүхэн хэсгийг л өгсөн.

*Та түүнийг ер бусын улсын сууగчид аас яльгүй доогуур  
бүтээж, түүнд яруу алдар, нэр хүндийн титмийг өмсгөсөн.*  
Дуулал 8:5

Хүмүүс Ертөнцийн Эзэнтэй ижил төстэй бүтээгдсэн тул бид бусад амьд бүтээлийн дэргэд их онцгой байр суурийг эзэлдэг. Хүмүүс “Ертөнцийн Эзэний” ангилалд багтдаггүйтэй адил “амьтны” ангилалд ч бас хамаардаггүй. Бид хоорондоо маш их ялгаатай. Зөвхөн хүнийг л Ертөнцийн Эзэнтэй ижил төстэй бүтээж, Ертөнцийн Эзэний яруу алдрыг хүртээсэн. Тиймээс Мөнхийн Эзэн зөвхөн хүмүүстэй л мөнхийн харилцаа тогтоохыг зэхж байв.

Хүний Ертөнцийн Эзэнтэй ижил төстэй өөр хүчин зүйлийн талаар ярьж болох ч энэ түүхээ цааш нь үргэлжүүлье.

	<b>Үүрэг</b>	<b>Ангилал</b>	<b>Нэр</b>
Ялгаатай →	Бүтээгч	Мөнхийн Эзэн	Яахвээх
Ялгаатай →	бүтээл	ер бусын элч	Гаврель, Михаагэл, Гэрэлтэх Нэгэн
Ялгаатай →	бүтээл	хүн	Болдоо, Ариунаа, Гэрлээ г.м.
	бүтээл	амьтан, шувуу, загас, шавьж г.м.	баавгай, бүргэд, цурхай, эрвээхэй г.м.

## Үлээж амь оруулав

... *Мөнхийн Эзэн хүнийг газар шорооны тоосоор бүтээгээд хамар уруу нь амь оруулах амьсгaa мэт сүнсээ үлээж хүнийг амьтай болгов.*

Эхлэл 2:7

Үлээж амь оруулсан гэдэг хэллэгийг хүний сүнслэг эсвэл биет бус талтай ихэнхдээ холbon үздэг. Мөнхийн Эзэн Яахвээх өөрөө сүнс учраас энэ нь түүний дүр төрхийн бас нэгэн тусгал юм. Сүнснүүд бие махбодгүй учраас үл үзэгддэг гэж өмнө нь ярилцсан. Гэхдээ хүний хувьд өөр. Ертөнцийн Эзэн хүнийг өөртэйгөө ижил төстэй бүтээсний дээр хүний сүнсэнд зориулж газрын тоосноос бүрдсэн махан биеийг өгсөн. Хүний бие махбод бүрэн бүрэлдсэнийхээ дараа ямар ч амьгүй хэвтэж байв. Ертөнцийн Эзэн хүний дотор сүнсийг үлээн оруулж, амилуулсан билээ. Зөвхөн Мөнхийн Эзэн л амьдралыг өгөх чадвартай. Өөр хэн ч биш. Хүнд, ер бусын элч нарт эсвэл бусад эр, эм бурхдад энэ чадвар байхгүй.

## Анд наиз

Яахвээхийн бүтээсэн хамгийн анхны бөгөөд цорын ганц хүнийг *Адаам* гэдэг. Энэ нь хүн гэсэн утгатай үг. Дараа нь Ертөнцийн Эзэн эмэгтэй хүнийг бүтээв.

*“Хүн ганцаараа байх нь сайн хэрэг бии. Би түүнд таарч тохирсон ханийг бүтээж өгье”* гэж Ертөнцийн их Эзэн Яахвээх хэлэв.

Эхлэл 2:18

*Ийнхүү Ертөнцийн их Эзэн Яахвээх хүнийг гүн нойронд автуулаад нэг хавиргыг нь авч шархыг нь арьсаар хааж сорvigүй эдгээв. Ертөнцийн их Эзэн Яахвээх эрэгтэй хүнээс авсан хавиргаар эмэгтэй хүнийг бүтээж хүн дээр авчрав.*

*Анхны хүн эхнэртэйгээ хамт хоёулаа чармай нүүцэн байсан ч ичихийг үл мэддэг байв.*

Эхлэл 2:21-22, 25

Энэ хэдхэн ишлэлээс үүдэн их халуун маргаан өрнөж ирсэн. Ертөнцийн Эзэн эмэгтэй хүнийг хоёрдугаар зэргийн хүн болгож бүтээсэн хэмээн зарим нь үздэг. Энэ ойлголт Библид хэлсэн

сургаалтай огт нийцдэггүй юм. Мөнхийн Эзэн эмэгтэй хүнийг эр хүний хавирганаас авч түүний анд найз болгохын тулд бүтээсэн болохоос, эмэгтэй хүнийг эр хүний зарц болгохын тулд өсгийнөөс нь авч бүтээгдэггүй. Ертөнцийн Эзэн эрэгтэй, эмэгтэй хоёр хүнийг найзаж нөхөрлөхийг л хүссэн.

Адаам эхнэртээ амьдрал өгөгч гэсэн утга бүхий Хаваах гэдэг нэрийг өгөв.

### Төгс сайхан цэцэрлэг

*Ертөнцийн их Эзэн Яахвээх дорно зүгт орших Ээдэн гэх нутагт цэцэрлэг байгуулаад тэндээ бүтээсэн хүнээ суурьшуулав.*


Эхлэл 2:8

Библид Ээдэн нутгийг үнэхээр төгс сайхан газар хэмээн дүрсэлсэн. Тансаг амттай жимсээр дүүрэн, загас бужигнасан цэнгэг устай, гайхмаар олон төрлийн ан амьтан элбэгтэй, үгээр илэрхийлшгүй газар байсан аж! Цаг агаар ч туйлын тохиромжтой байсан бололтой.

Бид Ээдэнийг яг ямар байсан талаар тун маруухан мэдлэгтэй ч Ертөнцийн Эзэний бүтээж өгсөн газар Адаам, Хаваах хоёр амьдралаа залгуулах гэж зүдрээгүй нь лавтай. Мөнхийн Эзэн бүх хэрэгцээг нь бүрэн хангаж өгсөн тул цэцэрлэгт бүх юм элбэг дэлбэг байв. Энэ бол амьдрахад хамгийн тохиромжтой, төгс орчин байжээ. Мөнхийн Эзэн үүгээрээ өөрийн хайр, нөхөрлөх сэтгэлээ илэрхийлсэн аж.

*Та нар Мөнхийн Эзэн Яахвээхийг Ертөнцийн Эзэн Элүхийм мөн гэдгийг хүлээн зөвшөөр! Биднийг тэр өөрөө бүтээсн агаад бид түүнийх юм. Бид түүний бэлчээр дэх хонин сүрэг мэт билээ.*

Дуулал 100:3



## 6. Их дээр оршдог ч бас ойрхон

Түүний бүтээсэн орчлон ертөнцийн зах хязгааргүй байдал, ээдрээтэй нарийн талууд, хуулиудынх нь бүтцийг авч үзээд аугаа их Бүтээгч Эзэн Яахвээхийн хосгүй мөн чанарыг “амьд оршигч” гэдэг үүднээс харах нь хүнийг гайхшуулж магадгүй.

## Үл тайлагдах нууц

Хамгийн ихээр бодсон ч Мөнхийн Эзэн Яахвээхийн тухай бидний мэдлэг туйлын хязгаарлагдмал байдаг. Mash их зүйл нууцлаг хэвээр байна.

*Мөнхийн Эзэн бол аугаа их нэгэн бөгөөд дээдийн дээд магтаалаа түүнд өргөх учиртай! Түүний нэр сур хязгааргүй их цэлгэр учраас ухаан санаанд багташгүй юм. Дуулал 145:3*

*Та нар мэдээгүй гэж үү? Та нар сонсоогүй юм уу? Мөнхийн Эзэн Яахвээх бол газар дэлхийн хязгаарыг бүтээсэн мөнхөд орших Ертөнцийн Эзэн мөн. ... түүний оюун ухааны цар хүрээг хэн ч гүйцэд ухаарч чадахгүй.* Яашаах 40:28

## Тайлагдсан нууц

Харин Яахвээхийн тухай илэрхий болсон зүйлс үнэхээр гайхалтай. Ертөнцийн Эзэн бол аугаа хэдий ч үл хүрэх холын нэгэн биш, тэрээр үл харилцдаг чимээгүй нэгэн ч биш.

*Мөнхийн Эзэн Яахвээх “Би харанхуй газраас нууцаар ярьдаггүй. Би зөвхөн шударгаар ярьж, зөв бүхнийг тунхагладаг” гэж хэлэв.* Яашаах 45:18-19

Тэр бол хүнтэй ярьдаг Эзэн. Тийм ээ, тэрээр өчүүхэн дорой хүмүүс бидэнтэй харьцдаг билээ.

*“Би асар их өргөмжлөгдсөн, ариун газар оршидог ч гэм буруугаа ухаарсан, төлөв даруу нэгнийг урамшуулж, гэмт амьдралаа орхисон нэгнийг зоригжсуулах аар тэдэнтий bas хамт байдаг” хэмээн ариун нэртэй дээдийн дээд Мөнх Оришихуй айлдав.* Яашаах 57:15

Тийм ээ, хосгүй Мөнхийн Эзэн Яахвээх их дээр залардаг ч бидний дунд оршдог. Тэр бол биднийг бүтээсэн аугаа их Бүтээгч Эзэн билээ.

*Мөнхийн Эзэн Яахвээх өөрийг нь дууддаг бүхэнд, өөрийг нь үнэнээр дууддаг бүхэнд ойрхон байдаг.* Дуулал 145:18

## Бүтээгч - эзэмшигч

Ертөнцийн Эзэн ер бусын элч нарыг бүтээсэн учраас тэд түүний мэдэлд байсантай адил Ертөнцийн Эзэн Адаам, Хаваах хоёрыг бүтээсэн учраас тэр хоёр ч бас түүний мэдэлд байв. (Завины сэлүүрийг хийж бүтээсэн хүн түүнийгээ эзэмшидгэг гэсэн омгоороо амьдардаг хүмүүсийн жишээг санацгаая.)

*Мөнхийн Эзэн Яахвээх газар дэлхий болоод түүнд дээр оршидог бүхний эзэмшигч нь мөн! Хорвоо ертөнцийн оршигчид бүгд түүнийх билээ!* Дуулал 24:1

*Мөнхийн Эзэн Яахвээх минь! Тэнгэр огторгуй, газар дэлхийн  
бүх юм таных учраас алдар нэр, аугаа их хүч, сурлэг байдал,  
яруу алдар, сүр жавхлан ч бас таных билээ!* Сүйрүн дээд 29:11

Ертөнцийн Эзэн ер бусын элч нарт өөрийнхөө зарц туслахын байр суурийг өгсөнтэй адил Адаам Хаваах хоёр, тэдний хойч үед газар дэлхийг харж хамгаалах үүргийг ногдуулсан юм.

*Ертөнцийн Эзэн тэр хоёрыг ивээж “Үр удам чинь олиширч,  
өнөр өтгөн болоод газар сайгүй амьдарч, энэ дэлхийг  
захирсугай. Далайн амьтад, тэнгэрийн шувууд болон  
газрын хөрсөн дээр хөдөлдөг бүхнийг захирч, энэ дэлхийг  
эзэгнэсүгэй” гээж айлдав.* Эхлэл 1:28

*Тэгээд Мөнхийн Эзэн Яахвээх хүнийг Ээдэний цэцэрлэгт  
суурьшулан уг газарт тариалан эрхэлж, арчлан хамгаалах  
үүргийг өгөв.* Эхлэл 2:15

## Анд наиз

Ертөнцийн Эзэн, Адаам Хаваах хоёрын бүхий л хэрэгцээг бүрэн хангаж өгсөн гэж сургаалд хэлсэн.

*Ертөнцийн Эзэн “Газар дэлхийн үр тээдэг бүх ургамал,  
үр тээдэг жимстэй бүх модыг би та нарын хоол хүнсэнд  
зориулан өглөө. Түүнчлэн төрөл бурийн өвс, ногоон ургамлыг  
энэ дэлхийн бүх араатан амьтан, жигууртэн шувууд болон  
газраар явагчдын [амьтай бүхний] тэжээл болгон өглөө”  
гэхэд бүх юм ёсоор нь болов.* Эхлэл 1:29-30

Библид Мөнхийн Эзэнийг өөрийгөө хүмүүст харагдуулахын тулд заримдаа хүний дүрсээр үзэгддэг тохиолдлын тухай тэмдэглэсэн байдаг бөгөөд энэ удаад Ертөнцийн Эзэн, Адаам Хаваах хоёрт хүний дүрсээр үзэгдсэн бололтой. Мөнхийн Эзэн Яахвээх үдшийн цагаар Адаам, Хаваах хоёртой жирийн наиз нөхөд шиг хамт зугаалахаар ирсэн гэж сургаалд хэлсэн.

Бүтээгч Эзэнтэйгээ хамт цэцэрлэг дундуур зугаална гэдэг үнэхээр ховор завшаан байсан болов уу. Ертөнцийн Эзэн тэр хоёрт хэрхэн бүхнийг бүтээнээ дэлгэрэнгүй тайлбарласан байж болох юм. Ээдрээтэй нарийн зохион байгуулалттай цэцэгсийн тухай асар ихийг мэддэгээ харуулж, модны оройд буй шувуудыг өөр дээрээ дуудаж, тоолохын аргагүй олон төрлийн ан амьтдын талаар ярилцсан болов уу. Тэрээр бүхнийг эмх замбараатай зохицуулдаг хуулийнхаа тухай ойлгуулсан байж болох юм. Тэр хоёр ямар их үнэ цэнэтэй мэдлэгийг, ямар хосгүй их багшаас олж сонссон бол oo! Цэцэрлэгийг хэрхэн харж хамгаалах талаар тэдэнд түүнээс өөр хэн ч ийм сайн зөвлөгөөг өгөхгүй байсан нь мэдээж.

Адаам, Хаваах хоёрт муу муухай мөн чанар байгаагүй тул Ертөнцийн Эзэний дэргэд байх эрхийг олгодог төгс мөн чанаарыг эзэмшиж байв. Библид зөвхөн төгс төгөлдөр хүмүүс<sup>7</sup> л төгс төгөлдөр Ертөнцийн Эзэнийхээ дэргэд орших боломжтой гэсэн.

Түүхийн энэ үед Ертөнцийн Эзэн хүн хоёрын хооронд найз нөхрийн холбоо тогтсон байв. Дэлхий бол амьдрахад хамгийн тохиромжтой, төгс газар байсан бөгөөд Ертөнцийн Эзэн ийм л замаар бүхнийг бүтээдэг.



### **Орчлон ертөнцийг бүтээх ажил дуусав**

*Мөнхийн Эзэн бүтээсэн бүхнээ хэчинээн сайхан болохыг харав.*

*Ийнхүү шөнө болжс өглөө ирснээр зургаадахь өдөр өндөрлөв.*

*Эхлэл 1:31*

Орчлон ертөнцийг бүтээх их ажил дуусав. Хүн, ажлыг тун ч идэвхийлэн эхэлдэг ч аажимдаа сонирхол нь буурдаг тал бий. Харин Ертөнцийн Эзэн бол өөр. Яахвээх төлөвлөсөн бүхнээ ямагт дуусгадаг.

*Мөнхийн Эзэний төлөвлөгөө мөнх өд бат оришино, түүний зүрхний зорилго үеийн үед ганхаагүй бат зогсоно.*

*Дуулал 33:11*

Зарим хүн орчлон ертөнцийг бүтээх ажил үргэлжилсээр байгаа гэдэг. Бурхдыг дэлхийтэй зууралдаар л байгаа гэж үздэг. Гэвч Библид өөр үгийг хэлсэн:

*Мөнхийн Эзэн Яахвээх тэнгэр огторгуй, газар дэлхий, далай тэнгис болон тэнд ориших бүхнийг зургаан өдөрт багтаан бүтээгээд долоодахь өдрөөт амрав.* *Чөлөөлөгдсөн нь 20:11*

### **Долоодахь өдөр**

Мөнхийн Эзэн Яахвээх долоодахь өдөр ажлаа дуусаад амрав. Тэрээр ядарсандаа амраагүй, харин орчлон ертөнцийг бүтээх ажлаа өндөрлөөд амарсан. Тэрээр энэ өдрийг Адаам Хаваах хоёртой өнгөрөөсөн байж болох юм. Бид үүнийг баттай мэдэхгүй. Гэхдээ орчлон ертөнцийг зөвхөн нэг л Ертөнцийн Эзэн бүтээсэн гэж Библид хэлснийг бид баттай мэднэ. Түүний нэр бол Мөнхийн Эзэн Яахвээх.

## Дүгнэлт

Ийнхүү бил эхлэлийн тухай уншсанаар энэ хосгүй Мөнхийн Эзэн Яахвээхийн талаар илүү ихийг мэдэж авлаа.

Яахвээх бол **мөнхөд орших сүнс**. Тэр бол цорын ганц Ариун Сүнс.

Яахвээх бол зүгээр хүч биш, харин **амьд нэгэн**.

Яахвээх бол **бүхнийг мэддэг, бүхнээс хүчирхэг, хаа сайгүй нэгэн зэрэг оршдог**.

Яахвээх бол эмх **цэгцийг дээдэлдэг**. Тэрээр бүхнийг эмх цэгцтэй байлгадаг хуулиудыг тогтоосон ба хуулиудаа тууштай баримталдаг.

Яахвээх бол цэвэр ариун, зөв шударга ёс суртахуунтай, **төгс төгөлдөр** Ертөнцийн Эзэн.

Яахвээх бол хайраар дүүрэн **анхаарал халамжтай** Ертөнцийн Эзэн.

Яахвээх бол үнэмлэхүй **аугаа** нэгэн хэдий ч хүнтэй **харьцдаг** Ертөнцийн Эзэн.

Энэ бүх тодорхойлолт түүний яруу *алдар* гэгддэгийн нэгэн хэсгийг бүрдүүлдэг. Энэ бүхэн цорын ганц, хосгүй Ертөнцийн Эзэнийг бүрэлдүүлдэг Яахвээхийн олон гайхамшигтай шинж чанаруудын хослол юм.

*“Мөнхийн Эзэнтэй эн зэрэгцэх ариун нэгэн угүй билээ ...”*

*Шимүүлийн дээд 2:2*

## Дарвина хувьслын онолын талаар

Библид хувьслын талаар нэг ч үг хэлээгүй. Энэ номын зорилго тухайн сэдвийг хөндөхөд оршоогүй ч цөөн хэдэн асуудлын тухай ярилцъя.

Зарим хүмүүсийн үздэгээр хувьслын онолыг шинжлэх ухаан хэмээж, харин орчлон ертөнцийг бүтээсэн явдлыг зүгээр шашин гэх нь зүйд нийцэхгүй. Яагаад тэр билээ?

❖ Бүх юм хэрхэн үүссэнийг тайлбарлах нэгдсэн нэг ойлголт байдаггүй. 1859 онд Чарльз Дарвин хувьслын онолыг анх танилцуулснаас хойш сонгодог Дарвинизмын онолыг хоорондоо ихээхэн зөрчилтэй өөр онолуудаар сольсоор ирсэн түүхтэй. Нео-Дарвинизм эсвэл Тэнцвэртэй Хөгжлийн онол гэх мэт.

Эдгээр онол орчин үеийн шинжлэх ухаантай зөрчилддөг болохыг олон эрдэмтэн олж тогтоосон. Жишээлбэл:

- **Сансар огторгуйн хувьслын онол физикийн хуулиудтай зөрчилддөг.** Орчлон ертөнц нь эхэн үеийн эмх замбараагүй байдлаас байнга өсөн нэмэгдэх эмх цэгтэй байдал уруу аажмаар хувьсдаг хэмээн энэ дэлхийн суртал ухуулга бидэнд заадаг. Гэтэл термодинамикийн хоёрдугаар хууль яг үүний эсрэг зүйлийг заадгийг бид одоо мэднэ. Өөрөөр хэлбэл аливаа тусгаарлагдмал тогтолцоо<sup>8</sup> нь цагийн аясаар улам бүр эмх замбараагүй байдалд шилждэг гэсэн хууль юм.
- **Хувьсал нь математикийн хувьд боломжгүй.** Үүний жишээ тун олон. Ажил амьдралынхаа дийлэнхийг Кэмбрижд өнгөрүүлсэн нэрт сансрын физикч, математикч Фред Хайл маш сонирхолтой харьцуулалтыг хийсэн. Тэрээр хамгийн энгийн эсийг байгалийнхаа жам ёсоор хувьсаж асар хүчтэй хүй салхи болж, эсвэл Бойнг онгоцыг угсрах хэмжээнд хүрэх боломжгүйг нотолсон байна.<sup>9</sup> Ийм зүйл хэзээ ч тохиолдохгүй аж.
- **Хувьсал нь биологийн шинжлэх ухаантай үл нийцдэг.** Жишээлбэл олон төрлийн нохойнуудыг хувьслын ачаар бий болсон гэж Дарвин бичсэн. Гэтэл тэрээр генетикчдийг яг үүнийх нь эсрэг нээлт хийхийг мэдээгүй. Генетикийн мэдээллийг багасгасны үр

дүнд олон үүлдрийн нохой бий болсон ба энэ нь хувьсал гэхээсээ илүү үл хувьсал болж хувирсан.<sup>10</sup>

- ❖ Хувьслын онолыг улайран баримтлагчид Бүтээгч байсныг огт хүлээн зөвшөөрдөггүй. Тэд хувьслыг хангалттай хугацааны туршид явагдах боломжтой гэж үздэг. Энэ нь шинжлэх ухаан дээр суурилсан гэхээсээ илүү итгэл дээр тулгуурласан үзэл бодол юм.

Нөгөө талаасаа орчлон ертөнцийг бүтээсэн явдлыг бүхлээр нь шашинастай холбож үзэх нь бас л буруу юм. Яагаад?

- ❖ Зөвхөн нэг зохион бүтээгч (Ертөнцийн Эзэн шиг) эсвэл зохион бүтээгчдийн бүтэн баг ажилласан тохиолдолд л энэ асар нарийн зохион байгуулалттай ертөнц бий болох боломжтой байсан гэдэг дүгнэлтэнд маш олон эрдэмтэн хүрсэн. Тэд зөвхөн шинжлэх ухаан дээр үндэслэж энэ орчлон ертөнц бүр хамгийн бичил түвшиндээ ч асар нарийн зохион байгуулалттай болохыг нотолсон.<sup>11</sup> Энэ нарийн зохион байгуулалт, эмх цэгц нь тохиолдлоор хувьсах ямар ч боломжгүй бөгөөд зөвхөн шууд л нэг дор бүтээгдсэн гэдгийг тэд харуулсан. Аливаа нарийн зохион байгуулалттай зүйлийг заавал хэн нэгэн бүтээсэн байdag учиртай аж.

1960-д оны дундаас энэ тухай маш ихээр бичих болсон (Хавсралтыг харна уу). Эдгээрийн дийлэнх нь тэргүүний шинжлэх ухааны хувьд өндөр боловсрол эзэмшээгүй хүмүүст ч ойлгомжтойгоор бичигдсэн юм.

Зарим хүн орчлон ертөнцийг бүтээх үйл явцад үлэг гүрвэл холбоотой эсэхд гайхдаг. Библийн зарчмын хувьд Ертөнцийн Эзэн үлэг гүрвэлүүдийг бусад бүх амьтдын хамт бүтээсэн гэдэгт үл итгэх шалтгаан байхгүй. Үлэг гүрвэл хүн хоёр нэгэн цаг үед хамт оршиж байсны нотолгоо бий. Харин юуны улмаас тэд устаж үгүй болсон талаар бүгдээрээ удахгүй үзнэ.

Бусад нь газар дэлхийн насны талаар ихээхэн маргадаг. Зарим хүмүүст дэлхий маш их өндөр настай мэт санагддаг. Эрдэмтэд орчлон ертөнцийн насыг тодорхойлох төрөл бүрийн аргачлалыг<sup>12</sup> боловсруулсан нь үнэн хэдий ч нарийн тооцоо хийгээд ирэхлээр тэд гайхширсандаа толгойгоо маажихад л хүрдэг. Ямар аргачлалыг хэрэглэнээс шалтгаалаад, дэлхийн нас хэдхэн мянгаас хэдэн тэрбум

жилийн насыг заадаг. Дарвин биологийн хувьслын үйл явцад 400 сая жилийн нас шаардлагатай гэж үзсэн. Харин өнөөдрийн дундаж тооцоо 4,6 тэрбум жилээс эхэлдэг. Хэний цаг үнэн зааж байна вэ?

Библид өгүүлсэн түүхтэй нийцэх үндэслэлтэй хариулт байна уу? Библид хэлснийг хатуу баримталваас Ертөнцийн Эзэн бүрэн гүйцэд боловсорсон дэлхийг бүтээснийг бид мэднэ. Адаам бүтээгдсэн өдрөө тэнгэр баганадсан өндөр ой modoор зугаалж, үй олон ан амьтдыг хараад гайхан шагширч, мөн шөнийн тэнгэр дэх оддыг шимтэн ширтэж байсан болов уу. “Ямар сайхан юм бэ! Энэ дэлхий бий болоод их удааж байгаа байх даа” гэж тэр бодсон нь лавтай. Ертөнцийн Эзэн газар дэлхийг дутуу юмгүйгээр бүрэн гүйцэд бүтээсэн бөгөөд их дээ л зургаахан хоногийн настай гэж хэлсэн байж таарна. Эрдэмтэд Адаамтай адилхан нүдээрээ харж буй зүйл дээрээ үндэслэн өнгөрсөн үеийг тодорхойлох гэж оролддог. Харин Библид тухайн үеийн амьд гэрч Ертөнцийн Эзний өөрийнх нь хэлснээр орчлон ертөнцийн үүслийг тодорхойлсон.

Яахвээх орчлон ертөнцийг бүтээсэн гэж хэлэхдээ яг дээрхийг бодож хэлсэн үү? Бид хэний үгэнд итгэх вэ?

Олон зууны өмнө нэгэн хаан дэлхийд эзлэх өөрийн байр суурийн талаар ийнхүү эргэцүүлж байв:

*Таны гарын хуруугаар бүтсэн шөнийн тэнгэр өөд шиরтэх дээ, огторгуйд хоосон орон зайнд тогтоосон сар, одод эрхэсийг тань харах даа, та юуны учир хүн төрөлхтнийг эрхэмд үзэжс, ийм их анхаарал хандуулдаг вэ гээж би өөрөөсөө асуудаг.*

*Та биднийг ер бусын улсын суугчidaас яльгүй доогуур бүтээжс, бидэнд яруу алдар, нэрхүндийн титмийг өмсгөсөн.*

*Та бидэнд бүтээсэн бүхнийгээ захирах үүргийг олгожс, бүхнийг бидний эрх мэдэлд үздээсэн. Хонь, үхэр, зэрлэг амьтан, жигүүртэн шувууд, далайн загас болон тэнгисийн урсгалыг зүснэ сөрөх бүх амьтныг та бидний мэдэлд өгсөн.*

*Яахвээх! Мөнхийн Эзэн Яахвээх минь! Дэлхий даяар түгсэн нэр алдар тань юутай их сүр жсавхлантай вэ!*

Дуулал 8:3-9